



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ
ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ:
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ЭХ/00/2023/05/12

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2023.02.10



ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	3
УДИРТГАЛ.....	4
ҮНДСЭН ХЭСЭГ.....	5
I. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС.....	5
II. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС.....	7
III. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС.....	9
IV. ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХАНТ УЛС.....	13
V. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС.....	20
ДҮГНЭЛТ.....	24
ЭХ СУРВАЛЖ	28
ХАВСРАЛТ.....	30



ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ

Америкийн Нэгдсэн Улс

БНХАУ

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

ОХУ

Оросын Холбооны Улс

ХБНГУ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ИБУИНХУ

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс



УДИРТГАЛ

Судалгааны зорилго, зорилт:

Тус судалгааны зорилго нь гадаадын зарим улс орны эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх процессын эрх зүйн зохицуулалтын онцлог, шүүхийн шийдвэрийн бүтэц агуулгыг харьцуулан судлахад оршино. Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа. Үүнд:

- Харьцуулсан судалгааны хүрээнд сонгон судалсан орнуудын эрүүгийн хэргийн хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны тухай ойлголт, онцлог;
- Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд шүүхээс тавих хяналтын цар хүрээ, эрх хэмжээ;
- Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн бүтэц, агуулга зэргийг тодруулахыг зорилоо.

Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгааны хүрээнд эх газрын болон жишгийн эрх зүйн тогтолцоотой орнуудыг төлөөлүүлэн ОХУ, БНХАУ, ХБНГУ, ИБУИНХУ, АНУ-д шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулсан буюу богино хугацаанд явуулах хэлбэр, зохицуулалтын онцлог, шүүгдэгчийн эрх зүйн хамгаалалт, шүүхийн эрх хэмжээ ба шүүхийн шийдвэрийн бүтцийг харьцуулан судаллаа.

Судалгааны арга зүй

Судалгааг гүйцэтгэхдээ эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжилж, нэгтгэн дүгнэх (анализ, синтез), баримт бичиг судлал, харьцуулсан судалгааны аргуудыг ашиглав.

Судалгааны бүтэц

Тус судалгаа нь Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт, хавсралт хэсгээс бүрдэнэ.



ҮНДСЭН ХЭСЭГ

НЭГ. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ-д шүүгдэгч өөрийг нь буруутгаж буй гэмт хэргийг үйлдсэн гэм буруугаа бүрэн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд явуулах эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг “**шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тусгай журам**” гэж нэрлэдэг.¹ Тус улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр бүлэгт хялбаршуулсан журмаар (ө.х тусгай журмаар) хэрэг хянан шийдвэрлэх зохицуулалтуудыг тусгажээ. Мөн бүлгийн 314 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “хөнгөн эсвэл хүндэвтэр гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгч өөрийг нь буруутгаж буй ялыг бүрэн хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэж, шүүх хуралдааныг ердийн журмаар явуулахгүйгээр тогтоол гаргуулах өргөдөл гаргах эрхтэй”. Шүүгдэгч өргөдөл гаргахдаа заавал өмгөөлөгчийн хамтаар гаргах бөгөөд шүүгдэгч болон түүний хууль ёсны төлөөлөгчөөс өмгөөлөгч сонгоогүй бол шүүхээс өмгөөлөгч томилж хууль зүйн зөвлөгөө авах эрхийг хангана.²

Ийнхүү өргөдөл гаргаснаар шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ердийн журмаас гадна³ тусгай журмуудыг баримтлан хэргийг хянан шийдвэрлэх ба дараах нөхцөл байдлуудыг шалгаж үзсэний үндсэн дээр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тусгай журмаар явуулж, шийтгэх тогтоол гаргаж болно. Үүнд:⁴

- 1) шүүгдэгч өргөдлийнхөө мөн чанар болон үр дагаврыг ухаарсан;
- 2) өргөдлийг сайн дураараа болон өмгөөлөгчтэй зөвлөлдсөний дараа гаргасан;
- 3) шүүгдэгчийн гаргасан өргөдлийг улсын болон хувиараа яллагч ба (эсвэл) хохирогч эсэргүүцээгүй.

Тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгдэгч, түүний өмгөөлөгчийг заавал оролцуулах ба хохирогч шүүх хуралдаанд оролцох тохиолдолд шүүгч түүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахгүйгээр гаргасан тогтоолын журам болон үр дагаврыг тайлбарлаж, түүний шүүгдэгчийн өргөдөлд хандах хандлагыг тодруулна.

Ийнхүү улсын яллагч шүүгдэгчийг юунд буруутгагдаж байгааг танилцуулснаар, харин хохирогчийн (эсвэл түүний төлөөлөгчийн) бичгээр гаргасан өргөдлийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн бол хохирогчийн (эсвэл түүний төлөөлөгчийн) шүүгдэгчийг юунд буруутгаж байгааг танилцуулснаар хэлэлцүүлэг эхэлнэ.⁵ Шүүх хуралдааны явцад шүүгч:

¹ Данила Олешко. *Особый порядок.*(2022)//(Данила Олешко. *Тусгай журам.*(2022)) <https://www.advokatoleshko.ru/blog/tpost/gjzrfu18x1-osobii-poryadok-chto-eto-takoe-zachem-nu>, (Сүүлд үзсэн: 2023.02.06).

² Мөн тэнд, 315 дугаар зүйл.

³ Мөн тэнд, 316 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Шүүгдэгч өөрийг нь буруутгаж буй гэмт хэргийг үйлдсэнээ бүрэн хүлээн зөвшөөрч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахгүйгээр хэргийг шийдвэрлүүлэх тухай өргөдөл гаргасантай холбоотой шүүх хуралдааныг энэ зүйлд заасан шаардлагуудыг харгалзан үзэж, энэ хуулийн 35, 36, 38 болон 39-р бүлэгт заасан журмын дагуу явуулна” хэмээн заажээ.

⁴ ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 316 дугаар зүйл. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/1727e0ac8e463dde080c9d7a4b41f679115b18e9/, (Сүүлд үзсэн: 2023.02.09).

⁵ Мөн тэнд, 316 дугаар зүйл.



- a) шүүгдэгчээс түүнийг юунд буруутгаж байгаа нь түүнд ойлгомжтой эсэх, яллах талтай санал нийлж байгаа эсэх;
- b) өөрийнхөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахгүйгээр хэргийг шийдвэрлүүлэх тухай өргөдлөө дэмжиж байгаа эсэх;
- c) энэ өргөдлийг сайн дураараа гаргасан эсэх;
- d) өмгөөлөгчтэйгөө зөвлөлдсөний дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүйгээр гаргасан шийтгэх тогтоолын үр дагаврыг ойлгож байгаа эсэхийг асууж тодруулна.

Энэхүү тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч хэрэгт цугларсан нотлох баримтуудыг ердийн журмын дагуу үнэлж, шинжлэх ажиллагаа явуулахгүйгээр, яллагдагчийн хувийн байдлыг тодорхойлсон нөхцөл байдал, ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөлүүдийг судалж болно. Хэрэв шүүгч шүүгдэгчийн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн үндэслэл эрүүгийн хэрэгт цугларсан нотлох баримтаар тогтоогдсон гэсэн дүгнэлтэд хүрвэл, шийтгэх тогтоол гаргах бөгөөд ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй эсвэл шүүгдэгчид эрүүгийн хариуцлага оногдуулахад хөнгөрүүлэх нөхцөл байдлууд тогтоогдохгүй бол үйлдсэн гэмт хэрэгт нь тохирох хамгийн хүнд хэлбэрийн ялын хэмжээг оногдуулна.⁶

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 316 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэж гарсан шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт шүүгдэгчийн хүлээн зөвшөөрсөн гэмт үйлдлийн тодорхойлолт, түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахгүйгээр шийдвэр гаргах урьдчилсан нөхцөлүүдийг биелүүлсэн тухай шүүхийн дүгнэлтийг агуулсан байх ёстой. Шүүгчийн нотлох баримтад хийсэн дүн шинжилгээг болон үүнийг хэрхэн үнэлснийг шийтгэх тогтоолд тусгахгүй.

Ийнхүү тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж шүүхийн шийтгэх тогтоол гарсан бол шүүгдэгч дараах нөхцөлөөр давж заалдах гомдол гаргаж анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулах эрх эдэлдэггүй байна. Үүнд:

- 1) давж заалдах шатны шүүхийн дүгнэлтүүд анхан шатны шүүхээс тогтоосон эрүүгийн хэргийн бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байх;
- 2) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн;
- 3) эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;
- 4) шийтгэх тогтоол шударга бус байсан;
- 5) энэ хуулийн 237 дугаар зүйлийн⁷ 1.2 дахь хэсгийн 1 дэх заалтад болон 1 дэх хэсэгт заасан нөхцөл байдлыг илрүүлсэн;
- 6) шүүхийн өмнөх шатанд байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан нөхцөлийг дагаж мөрдөөгүй болон үүргээ биелүүлээгүй болохыг харуулсан мэдээллүүдийг илрүүлсэн.

⁶ Мөн тэнд.

⁷ ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 237 дугаар зүйл. Эрүүгийн хэргийг прокурорт буцаах тухай, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/f083dc00a2b033a526098e055c402de80440f34c/ (Сүүлд үзсэн: 2023.02.09).



ХОЁР. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

БНХАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 15 дугаар зүйлд зааснаар “Гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч өөрийн гэмт үйлдлээ үнэнээр нь мэдүүлсэн, яллагдаж буй үйл баримт, шийтгэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хуульд зааснаар хөнгөрүүлж шийдвэрлэх”-ээр тусгажээ.⁸ Сэжигтэн гэм буруу, оногдуулах эрүүгийн хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн бол прокурор түүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх, гэм буруу, оногдуулах ялыг хүлээн зөвшөөрөх үр дагаврын талаар хуулийн зохицуулалтыг танилцуулж, сэжигтэн, өмгөөлөгч эсхүл жижүүрийн хуульч, хохирогч (түүний төлөөлөгч)-с гаргасан “сэжиглэгдэж буй гэмт хэргийн үйл баримт, эрүүгийн хариуцлагаас хөнгөлөх, чөлөөлөх санал, шүүхээр шийдвэрлэхэд тохирох журам болон бусад санал”-ыг хэрэгт хавсаргана. Ийнхүү гэмт хэргийн сэжигтэн сайн дураараа гэм буруугаа хүлээн зөвшөөрч, оногдуулах эрүүгийн хариуцлага болон хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхийг хүлээн зөвшөөрсөн бол өмгөөлөгч эсхүл жижүүр хуульчийг байлцуулан гэм буруу, эрүүгийн хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн батламжид гарын үсэг зурна.

Прокурор хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх нөхцөлийг хангаж байгаа хэргийг 10 өдрийн дотор /1 жил хүртэлх хугацаатай хорих ял оногдуулах гэмт хэргийг 15 хүртэлх хоногоор сунгаж болно./ үндсэн ял, нэмэгдэл ял, тэнсэх харгалзах эсэх зэрэг яллах саналыг гаргаж гэм буруу, эрүүгийн хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн батламж зэрэг бусад материалын хамт шүүхэд шилжүүлнэ. Сэжигтэн гэмт хэргээ сайн дураар хүлээн зөвшөөрсөн нь улсын ашиг сонирхолд онцгой гавьяатай тохиолдолд Ардын дээд прокурорын газрын зөвшөөрлөөр цагдаагийн газар хэрэг нээхгүй эсхүл; ардын прокурорын газар нэг эсхүл, хэд хэдэн эрүүгийн хэрэгт яллахгүй байж болно.

Дээрх журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд шүүхийн мэтгэлцээн, байцаалтын ажиллагаа ерөнхийдөө явуулахгүй ч өмгөөлөгчийн санал, шүүгдэгчийн эцсийн үгийг шийдвэр гаргахаасаа өмнө зайлшгүй сонсоно. Яллагдагч гэм буруу, оногдуулах ялыг хүлээн зөвшөөрснийг шүүх хуралдаан даргалагч түүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх, гэм буруу, оногдуулах ялыг хүлээн зөвшөөрсний үр дагавар, журмыг танилцуулж, үнэхээр өөрөө зөвшөөрсөн эсэх, батламжийн бодит шинж, хуульд нийцсэн эсэхийг шалгана. Түүнчлэн шүүх шийдвэр гаргах үедээ ардын прокурорын газрын зүйлчлэл, оногдуулах ялын хэмжээнээс гадна дараах зүйлсийн шалгана. Үүнд:

- Гэмт хэргийн шинж бий эсэх;
- Өөрөө хүлээн зөвшөөрөх хүсэл сонирхлыг зөрчсөн эсэх;
- Гэмт хэргийн үйл баримтад маргасан эсэх;
- Яллагдаж буй зүйлчлэлд шүүхийн шатанд маргаж буй эсэх;
- Шударгаар шүүлгэхэд нөлөөлсөн бусад шалтгаан бий эсэх.

Ардын прокурорын газар яллах үед буюу шүүхэд шилжүүлэх үедээ Ардын шүүхэд хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх хүсэлт гаргана. Анхан шатны шүүхийн харьяаллын дагуу 3 жилээс доош хугацаагаар хорих ял оногдуулах хэргийн үйл баримт

⁸ 中华人民共和国刑事诉讼法, БНХАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, <https://www.pkulaw.com/chl/5a06769be1274052bdfb.html?keyword=%E5%88%91%E4%BA%8B%E8%AF%89%E8%AE%BC%E6%B3%95&way=listView>, (Сүүлд үзсэн: 2023.01.31).



тодорхой, нотлох баримт хангалттай түүнчлэн, яллагдагч гэм буруу, оногдуулах ял болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэхийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд эрүүгийн хэргийг шүүгч дангаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой.⁹ Шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх тохиолдолд 10 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд 1 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэгт 15 хүртэлх хоногоор сунгаж болно. Харин дараах тохиолдолд хялбаршуулсан журмыг ашиглаж болохгүй. Үүнд:

- Яллагдагч сохор, дүлий, хэлгүй эсхүл өөрийгөө таних чадвараа бүрэн алдсан эсхүл өөрийн үйлдлээ хянах чадвараа алдсан сэтгэцийн өвчтэй;
- Насанд хүрээгүй;
- Үйлдсэн гэмт хэрэг нь нийгэмд чухал нөлөөтэй;
- Гэмт хэргийн зарим хамтран оролцогч хэргийн зүйлчлэл, ялын хэмжээ, хялбаршуулсан журам ашиглахыг зөвшөөрөөгүй;
- Яллагдагч, хохирогч эсхүл хууль ёсны төлөөлөгч хохирлыг барагдуулах эвлэрлийн гэрээ байгуулаагүй;
- Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжгүй бусад нөхцөл байдал.

2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийг хэрэглэх талаарх Ардын дээд шүүхийн тайлбарын 366, 374 дүгээр зүйлүүдэд хялбаршуулсан эсхүл хурдавчилсан журмаар хэргийг шийдвэрлэх тохиолдолд шүүхийн шийдвэрийг “хялбарчилж” болно гэж тусгасан боловч эрүүгийн хэргийн шүүхэд нийтлэг дагаж мөрдөхөөр тодорхойлсон шүүхийн шийдвэрийн бүтэц, аргачлал байхгүй байна.¹⁰

Ийнхүү тус улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас хэргийг хялбаршуулсан болон хурдавчилсан журмаар шийдвэрлэсэн хэргийн шүүхийн шийдвэрийг харьцуулж үзэхэд хэлбэрийн хувьд ялгаагүй байна.¹¹ Харин зарим муж, хотын шүүхүүд дээрх тайлбарын 366, 374 дүгээр зүйлийн хүрээнд тухайн шүүхийн хэмжээнд үйлчлэх хэлбэр, бүтцийг тодорхойлон мөрдөж байна. Тухайлбал, 2022 оноос Хятад улсын зарим шүүхүүдэд хурдавчилсан журмаар шийдвэрлэсэн шүүхийн тогтоолыг “Хүснэгт” хэлбэрээр гаргасан нь цаг хэмнэсэн, иргэдэд тун ойлгомжтой, шүүхийн тогтоолын жишиг бүтэц болжээ.¹²

Гурав. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ GERMAN УЛС

ХБНГУ-ын Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн 6 дугаар хэсэгт эрүүгийн хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх: **хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх** болон **хурдавчилсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх** гэсэн хоёр төрлийг хуульчилжээ.¹³

⁹ Мөн тэнд, 214-222 дугаар зүйл.

¹⁰ 最高人民法院于<中华人民共和国刑事诉讼法>的解释, БНХАУ-ын Ардын дээд шүүхийн тайлбар, 2021. Цахим холбоос: <https://www.court.gov.cn/zixun-xiangqing-286491.html>, (Сүүлд үзсэн: 2023.01.31).

¹¹ Хавсралт №2-ийг үзнэ үү.

¹² Хавсралт №3-ийг үзнэ үү.

¹³ **Strafprozeßordnung (StPO)**, Эрүүгийн процесс ажиллагааны хууль, "Strafprozeßordnung in der Fassung der Bekanntmachung vom 7. April 1987 (BGBl. I S. 1074, 1319), die zuletzt durch Artikel 2 des Gesetzes vom 25. März 2022 (BGBl. I S. 571) geändert worden ist", <https://www.gesetze-im->



Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх

Хөнгөн гэмт хэрэг (*vergehen*)-т¹⁴ шүүх хуралдаан хийхгүйгээр ял оногдуулсан шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа (*Strafbefehlsverfahren*)-г эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §§ 407-412-т заасан байна. Хорих ялын дээд хэмжээ нэг жилээс доош, эсхүл торгуулийн ял оногдуулахаар заасан хөнгөн гэмт хэргүүдэд яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх ноцтой сэжиг байхад л хангалттай гэж үздэг байна. Энэхүү ажиллагааг эхлүүлэхийн тулд прокурор ял оногдуулсан шийдвэр гаргуулах тухай хүсэлт (цаашид “Прокурорын хүсэлт” гэх)-ийг эрүүгийн процесс ажиллагааны хуулийн § 407.1-т зааснаар шүүхэд бичгээр гаргана.¹⁵ Прокурорын хүсэлтэд дараах үндсэн болон нэмэгдэл ялыг оногдуулахаар тусгаж болно. Үүнд:

- Мөнгөн торгуул, (§ 40 ff. StGB)
- Ял гүйцэтгэхгүйгээр сануулах, (§ 59 StGB)
- Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, (§ 44 StGB)
- Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хураах, (§ 73 StGB)
- Хуулийн этгээд эсвэл хуулийн этгээдийн гишүүнийг торгох (§ 30 OWiG)
- 2 жилээс илүүгүй хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, (§ 69–69b StGB)
- 1 жилээс 3 жил хүртэлх хугацаанд амьтантай харьцах эсвэл амьтан тэжээх, худалдан авахыг хориглох ,(§ 17 ff Tierschutzgesetz,)
- Ялаас татгалзах (§ 60 StGB)

Прокурорын хүсэлтэд дараах зүйлсийг тусгана. (§ 409 StPO)

1. Яллагдагч болон хамтран оролцогчийн хувийн мэдээлэл;
2. Өмгөөлөгчийн нэр;
3. Яллагдагчийг ямар гэмт хэрэгт буруутгаж байгаа болон гэмт хэрэг үйлдсэн газар, хугацаа;
4. Баримталсан хуулийн нэр, хэсэг, зүйл, заалт;
5. Нотлох баримт;
6. Эрх зүйн үр дагаврыг тодорхойлох;
7. Ял оногдуулсан шүүхийн шийдвэрт гомдол гаргах боломж мөн гомдол гаргах хугацааг тусгах бөгөөд хуульд заасан хугацаанд гомдол гаргаагүй бол ял оногдуулсан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох тухай сануулга зэрэг.

Прокурорын хүсэлтэд хорих ял оногдуулахаар тусгасан бол яллагдагчийн өмгөөлөгч авах эрхийг хангах бөгөөд хэрэв яллагдагч өмгөөлөгчөө сонгоогүй бол шүүгч үүргийн өмгөөлөгч (*Pflichtverteidiger*) томилно. Шүүгч прокурорын хүсэлтийг хүлээн авч гэмт хэрэгт үйлдсэн гэх хангалттай баримт байгаа эсэх болон прокурорын хүсэлтэд дурдсан ялын санал сэжигтний үйлдсэн гэмт хэрэгт тохирсон эсэхийг хянаана. Шүүгч прокурорын хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд ял оногдуулах шийдвэр¹⁶, эсвэл мөн шийдвэрийг гаргахаас татгалзаж болно. Шүүгч ял оногдуулсан шийдвэр гаргасан тохиолдолд яллагдагч шүүхийн

internet.de/stpo/. (Сүүлд хандсан 2023.02.01).

¹⁴ Эрүүгийн зөрчил гэж нэг жилээс бага хорих ял эсвэл мөнгөн торгуулийн ял оногдуулахаар заасан хууль бус үйлдлийг хэлнэ. (§ 12.2 StGB).

¹⁵ Харин татварын гэмт хэргүүдэд татварын хууль¹⁵-ийн 400-д зааснаар татварын эрх бүхий байгууллагын ажилтан ял оногдуулсан шийдвэр гаргуулах хүсэлтийг шүүхэд гаргадаг.

¹⁶ “Хавсралт-4”-т ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн жишээ харуулав.



шийдвэрийг гардан авснаас хойш 2 /хоёр/ долоо хоногийн дотор гомдол гаргаагүй бол тухайн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно. Хэрэв яллагдагч эсвэл түүний төлөөлөгч шүүхийн шийдвэрт гомдол¹⁷ гаргах бол гомдлыг ял оногдуулсан шүүхийн шийдвэр гаргасан шүүхэд бичгээр эсвэл шүүхийн эрх бүхий ажилтанд амаар гаргаж болох бөгөөд амаар гомдол гаргасан тохиолдолд тэмдэглэл хөтөлнө. Харин бичгээр гаргах гомдлыг факсаар гарын үсэг зурахгүйгээр гаргаж болно.¹⁸ Яллагдагч хуульд заасан хэлбэр, хугацаанд гомдол гаргасан бол шүүгч шүүх хуралдаан хийх хугацааг товлон. Яллагдагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй, мөн яллагдагч шүүх хуралдаанд өмгөөлөгчөөр төлөөлүүлээгүй бол ял оногдуулах шүүхийн шийдвэрийн гомдлоос татгалзана.¹⁹

Хурдавчилсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §§ 417- 420 дугаар зүйлд эрүүгийн хэргийг хурдавчилсан журмаар хянан шийдвэрлэх талаар зохицуулжээ.²⁰ Прокурор тухайн хэрэг ээдрээ төвөгтэй биш энгийн эсвэл илэрхий нотлох баримтын үндсэн дээр хэргийг шууд шүүх хуралдаанаар хэлэлцэж болно гэж үзсэн тохиолдолд хурдавчилсан журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргана. Хэргийн нөхцөл байдал ээдрээ төвөгтэй биш гэдэгт хэргийн оролцогч талуудад хэргийн баримтууд ойлгомжтой байхыг хэлнэ.²¹ Харин илэрхий нотлох баримт гэж сэжигтэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн эсвэл хангалттай, баталгаатай нотлох баримт байгааг ойлгоно. Хорих ялын дээд хэмжээ 1 жилээс дээшгүй байх гэмт хэрэгт эсвэл тээврийн хэрэгслийн гэрчилгээ хураах таслан сэргийлэх арга хэмжээ авах бол хурдавчилсан журмаар хэргийг хянан шийдвэрлэдэг.²² Прокурор хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлтээ шүүхэд бичгээр гаргана. Шүүх ялын саналыг хүлээн авч хэргийг хурдавчилсан журмаар хянан шийдвэрлэхэд тохирох эсэх, гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай сэжиг байгаа эсэх, шүүх хуралдааны урьдчилан нөхцөл хангасан эсэхийг хянаж үзээд шууд эсвэл богино хугацааны дотор шүүх хуралдааны бэлтгэл ажил хийхгүйгээр шууд шүүх хуралдааныг зарлана. Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн § 418.2-т шүүх прокурорын саналыг хүлээн авснаас хойш 6 долоо хоногийн дотор шүүх хуралдааныг зарлан хуралдуулна. Ингэхдээ шүүгдэгчид 24 цагийн дотор шүүх хуралдааны товыг шүүхийн мэдэгдэх хуудсаар хүргүүлдэг байна. Прокурор шүүгдэгчийг 6 сараас дээш хугацаагаар хорих ялын санал гаргасан тохиолдолд өмгөөлөгчийг заавал оролцуулна. Хэрэв шүүгдэгч өмгөөлөгчгүй бол шүүх үүргийн өмгөөлөгч томилдог байна.

Эрүүгийн процесс ажиллагааны явцад талууд тохиролцох нь

¹⁷ “Хавсралт-б”-т Гомдол гаргасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг харуулав.

¹⁸ Шүүхийн шийдвэр. BverFG DAR 2002, 411.

¹⁹ “Хавсралт53”-т “ ял оногдуулсан шүүхийн шийдвэрт гаргасан гомдлоос татгалзах тухай” шүүхийн шийдвэрийн жишээг харуулав.

²⁰ Холбооны Статистикийн албанаас гаргасан мэдээллээр 2017 онд Германд 654.537 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэснээс орон нутгийн шүүхүүдэд 14.537 эрүүгийн хэргийг хурдавчилсан журмаар хянан шийдвэрлэсэн байна.

https://beckassets.blob.core.windows.net/product/readingsample/27274142/27274142_9783811445222_1_eseprobe_02.pdf. (Сүүлд үзсэн: 2023.01.31).

²¹ Strafbefehlsverfahren und beschleunigtes Verfahren. Хялбаршуулсан болон хурдавчилсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, 393 дахь хэсэг. https://beckassets.blob.core.windows.net/product/readingsample/27274142/27274142_9783811445222_1_eseprobe_02.pdf (Сүүлд үзсэн: 2023.01.31).

²² Эрүүгийн процесс ажиллагааны хууль, § 419.1.



Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг богино хугацаанд явуулах, хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлснээр хохирогчийн эрхийг хангах, гэмт буруугаа хүлээсэн бол хөнгөн ял оногдуулах баталгааг олгох нь тохиролцооны зорилго болно.²³ Герман Улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд тохиролцоонд хүрэхийг “**Verständigungen**” хэмээн нэрлэдэг. Тухайн улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг 4 үе шаттай хэрэгждэг гэж үздэг. Дурдвал: хэрэг бүртгэлийн үе шат, завсрын үе шат²⁴, шүүх хуралдааны үе шат, шүүхийн шийдвэрийг давж заалдах үе шат болно. Энд дурдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудын эхний гурван үе шат болох хэрэг бүртгэлийн үе шат, завсрын үе шат, шүүх хуралдааны үе шатанд талууд хоорондоо тохиролцож болно гэж үздэг. Тохиролцоо нь үндсэн шүүх хуралдааны үед шүүхээс санал болгосон тохиролцоог яллагдагч болон прокурор хүлээн зөвшөөрснөөр хэрэгжинэ гэж үздэг ч шүүх хуралдаанаас гадуур сайн дурын үндсэн дээр хэрэг бүртгэлийн үе шат болон хэрэг хянан шийдвэрлэх завсрын үе шатанд тохиролцооны талаар хэлэлцүүлж болох боломжийг хуулиар олгосон байна.

Хэрэг бүртгэлийн үе шатанд талууд тохиролцооны талаар хэлэлцэх нь /§ 160b StPO/

Хэрэг бүртгэлийн үе шатанд тохиролцоонд хүрэх боломжтой байдаг. Энэ шатанд прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулахад тохиромжтой гэж үзвэл хэргийн оролцогчтой процессын байдлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж болно. Процессын байдлын талаар хэлэлцүүлэх боломж олгож байгаагийн зорилго нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төгсгөлд талууд тохиролцоонд хүрэх явдал юм. Хэлэлцүүлэг нь албан ёсны байхыг шаардахгүй бөгөөд хэргийн бүх оролцогч биечлэн тухайн хэлэлцүүлэгт оролцох албагүй. Тохиролцоог утсаар харилцан ярилцаж хийж болно гэж үздэг. Хэлэлцүүлэгт сэжигтэн гэм бураагаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд энэ тухай тэмдэглэлд тусгана.²⁵

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны завсрын үе шатанд тохиролцооны талаар хэлэлцэх нь /§ 202a StPO/

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхэн үед процессыг түргэн шуурхай явуулахад тохиромжтой гэж үзвэл хэргийн оролцогчидтой мөн адил процессын байдлын талаар хэлэлцэж болно.

Үндсэн шүүх хуралдаан дээр прокурор ялын санал танилцуулсны дараа даргалагч шүүгч хэрэг бүртгэлийн үе шат болон завсрын үе шатанд дээрх хэлэлцүүлэг болсон эсэх, тухайн хэлэлцүүлгээр талууд тохиролцоо боломж байсан эсэх, хэрэв талууд тохиролцоонд хүрсэн бол түүнийг агуулгыг танилцуулна.

Шүүх хуралдааны үе шатанд тохиролцоо нь /§257c StPO/

Тохиролцооны гол зохицуулалт нь эрүүгийн процесс ажиллагааны хуулийн § 257c бөгөөд энэхүү зохицуулалтыг “сонгодог” тохиролцооны зохицуулалт хэмээн нэрлэдэг байна.

²³ Die Verständigung im Strafverfahren, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь тохиролцоо.

²⁴ Zwischenverfahren буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны завсрын үе шат гэдэг нь “Хэргийг шүүхэд хэлэлцэх эсэхийг хянан шалгах процесс ажиллагаа юм”.

²⁵ Was ist ein sogenannter strafrechtlicher Deal, “эрүүгийн эрх зүй дэх тохиролцоо гэж юу болох, https://www.anwalt.de/rechtstipps/was-ist-ein-sogenannter-strafrechtlicher-deal-verstaendigung-im-strafprozess-sinnvoll-oder-nicht_116652.html, (Сүүлд үзсэн: 2023.01.31).



Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн § 257с -г задлан авч үзвэл:

1. Тохиролцооны хүрээ: /§ 257с 1/ Шүүх хуралдааны үе шатанд шүүх тохирох хэргүүдэд хэргийн оролцогчидтой процессын цаашдын үйл явц болон үр дүнгийн талаар тохиролцож болно. Тохиролцоонд хүрэх боломжтой гэмт хэргүүдийн тухайд эрүүгийн процесс ажиллагааны хуульд **“тохирох хэрэгт”** тохиролцож болно хэмээн тусгасан ч ямар хэрэгт тохиролцож болохгүй талаар тусгаагүй байна.

2. Тохиролцооны зүйл: /§ 257с 2/ Тохиролцооны зүйл нь эрх зүйн үр дагавар бүхий 1) Шүүхийн шийдвэрийн агуулга болон түүнд холбогдох захирамж, 2) Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой бусад арга хэмжээ, 3) Хэргийн оролцогчдын процесс үйлдлүүд хамаарна. Тохиролцооны зүйлийг задлан авч үзвэл:

- Эрх зүйн үр дагавар бүхий шүүхийн шийдвэр болон түүнд холбогдох захирамжуудын агуулга нь тохиролцооны зүйл болно. Тухайлбал: нэмэгдэл ял, нэмэгдэл хор уршгийн ял болох гэмт хэргийн улмаас олж авсан эд хөрөнгийг хураах, цагдан хорих хугацааг сунгах, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зэргийг тохиролцооны зүйлд хамруулж ойлгоно. Харин үндсэн ял шийтгэл, таслан сэргийлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тохиролцооны зүйл болохгүй бөгөөд шүүх зөвхөн ял шийтгэлийн дээд болон доод хязгаарыг л тогтоох эрхтэй байна. Хэрэв тогтсон ялыг тохиролцооны зүйлээр хүлээн зөвшөөрвөл ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал нь өмнөх хэлэлцээрт тулгуурлан гарах учраас хууль тогтоогч тохиролцооны зүйлд тогтсон ялын хэмжээ байхыг хүлээн зөвшөөрөөгүй байна.²⁶ Ялын дээд болон доод хэмжээг тохиролцоонд тусгахдаа яллагдагчийг хуульд заагаагүй ял шийтгэлийн хэмжээгээр сүрдүүлэхийг хориглоно. Жишээлбэл: хэрэв та гэм буруугаа хүлээн зөвшөөрвөл 2 жилийн хорих ялаар тохиролцоо боломжтой харин тохиролцоонд хүрээгүй бол хамгийн багадаа 6 жилийн хорих ял авна хэмээн сүрдүүлэхийг хориглоно.²⁷

- Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой бусад арга хэмжээ. Тухайлбал, хэрэгт авагдсан нотлох баримт /байцаалт авсан үеийн бичлэг/ зэргийг тохиролцооны зүйл болгоно.

- Хэргийн оролцогчийн процесс үйлдэл: Нотлох баримт гаргаж өгөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлөхөө хүлээн зөвшөөрөх зэрэг хэргийн оролцогчийн үйлдлүүд тохиролцооны зүйл болно.

3. Тохиролцооны агуулга: Хуульд тохиролцооны агуулгыг тусгаагүй, нээлттэй үлдээсэн байна. Шүүх тохиролцоонд ямар агуулга тусгахыг зарлана. Хэргийн оролцогчид байр сууриа илэрхийлэх боломжтой. Шүүхийн саналыг яллагдагч, прокурор хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тохиролцоо биелнэ. Тохиролцооны агуулгад сэжигтэн гэм буруугаа хүлээсэн эсэх мөн шүүхээс ял шийтгэлийн дээд, доод хязгаарын талаарх мэдээллийг тусгасан байна.

4. Нотлох баримт үнэлэх: Шүүх шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн итгэл үнэмшил төрөх хүртэл тухайн хэргийн бодит байдлыг тогтоох үүрэг нь хэвээр байна. Тиймээс шүүхийн шийдвэрийн үндэслэлд хоосон гэм буруугаа хүлээсэн илэрхийллийн агуулга хангалтгүй гэж үздэг. Мөн гэм буруугаа хүлээсэн тохиролцоо бүрд шүүх үнэнийг шалгах аргаар нотлох баримтыг үнэлнэ. Тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай, гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн гэж үзвэл шүүхээс тохиролцооны санал тавих бөгөөд яллагдагч болон прокурорын хүлээн зөвшөөрснөөр тохиролцоо биеллээ олно. Хэрэв талууд тохиролцоонд хүрсэн бол шүүхийн

²⁶ Мөн тэнд.

²⁷ BGH StV 2007, 619.



шийдвэрийн үндэслэх хэсэгт энэ талаар дурдана. Харин тохиролцоонд хүрээгүй тохиолдолд энэ тухай хурлын тэмдэглэлд тусгадаг байна.

Шүүхийн шийдвэрийн бүтцэд хийсэн товч дүн шинжилгээ²⁸

Яллагдагч Ф нь 103 удаагийн үйлдлээр бизнесийн харилцаанд хахууль авсан гэм хэрэгт холбогдсон байна. Тэрээр хэрэг бүртгэлийн үе шатанд гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бөгөөд Мюнстер орон нутгийн шүүх 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дугаар **12 Ls-45 Js 829/11-97/12** шүүхийн шийдвэрээр түүнд ял оногдуулахдаа эрүүгийн процесс хуульд заасан тохиролцооны үндсэн дээр ял оногдуулсан байна. Уг шүүхийн шийдвэрийн бүтцийг судлан үзвэл:

- ✓ Шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт: “Энэхүү шүүхийн шийдвэр нь эрүүгийн процесс ажиллагааны хуулийн 257 с дугаар зүйд заасан тохиролцоонд үндэслэв.” хэмээн тусгасан байна.
- ✓ Тухайн хэргийн үйл баримт нотлох баримтаар тогтоогдсон талаар тусгахдаа:

Шүүхийн шийдвэрийн үндэслэлийн 9 дэх хэсэгт “Шүүх хуралдааны тэмдэглэлд тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны агуулга болон үр дүнд шүүхийн итгэл үнэмшлээр доорх нөхцөл байдал тогтоогдов” хэмээн дурдаж шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл бүхий нотлох баримтууд болон тэдгээрийн агуулгыг дурдсан байна.

- ✓ Шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн талаарх үйл баримтыг дурдахдаа:
 - Шүүхийн шийдвэрийн үндэслэлийн 21 дэх хэсэгт “Яллагдагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа бүрэн хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хэргийн баримтуудыг тогтоов. Шүүх яллагдагчийн мэдээлэлд эргэлзэх шалтгаан алга”, мөн шүүхийн шийдвэрийн үндэслэлийн 26 дахь хэсэгт “Шүүгдэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шатанд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тул эрүүгийн хариуцлагын хэмжээг шүүгдэгчид ашигтайгаар дүгнэв” хэмээн тус тус дурдсан байна.
- ✓ Шүүхийн шийдвэрийн 38 дахь талд “Шүүгдэгч нь байнгын ажил хөдөлмөр эрхэлдэг, гэр бүлтэй мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхэн үед гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн нөхцөлүүдийг харгалзан шүүх тэнсэн харгалзах ял оногдуулах үндэслэлтэй гэж шийдвэрлэжээ.

ДӨРӨВ. ИБУИНХУ

Их Британи улсын эрүүгийн процесс ажиллагаанд **“plea guilty”** буюу яллагдагч, шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээх практик нэлээд түгээмэл хэрэгждэг. Гэмт этгээд аль болох эрт үе шатанд гэм буруугаа хүлээх нь хохирогчийн эрхийг хамгаалах, эрүүгийн процессын зорилгыг хангахад нийцнэ гэж үздэг ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт уг эрхийг хангаж ажиллана. Судалгааны энэ хэсэгт ИБУИНХУ-ын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд шүүгдэгч гэм буруугаа сайн

²⁸ Мюнстер орон нутгийн шүүхийн 2014 оны 4 дүгээр сарын 01-ны өдрийн дугаар **12 Ls-45 Js 829/11-97/12 шүүхийн шийдвэрийг ашиглав.** <https://ra.de/urteil/aq-munster/12-ls-45-js-82911-9712-2014-04-01?fbclid=...> (Сүүлд үзсэн: 2023.01.31).



дураар хүлээх боломж ба процесс, гэм буруугаа сайн дураар хүлээх төрлүүд, гэм буруугаа хүлээсэн мэдэгдлээс татгалзах, прокурор яллагдагчтай хэргийн үйл баримтын талаар тохиролцоонд хүрэх ажиллагааны талаар танилцуулна.

Яллагдагч, шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөх хоёр төрөл байна. Үүнд²⁹:

- а) “*charge bargaining*”- шүүгдэгч прокурорын яллаж буйгаас хөнгөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайгаа хүлээн зөвшөөрөх. Жишээ нь: Прокуророос шүүгдэгчийг хүний амь насыг санаатайгаар хөнөөх гэмт хэрэгт ялласан бол шүүгдэгч өөрөө болгоомжгүйгээр хүний амь нас хохироох гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайгаа хүлээн зөвшөөрөх.
- б) “*sentence bargain*”- Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр түүнд оногдуулах ял шийтгэлийг хөнгөрүүлэх зэрэг болно.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатууд дахь гэм буруугаа хүлээх боломж ба процесс: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд шүүгдэгч гэм буруугаа хүлээж болно. Үүнийг дэлгэрүүлэн авч үзэх үүднээс тус улсын гэмт хэргийн ангилал, шүүхийн харьяалал, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагааны үе шатуудыг товч тайлбарлах нь зүйтэй.

ИБУИНХУ-д эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх чиг үүргийг магистратын шүүх болон “*Crown court*”³⁰-д хэрэгжүүлдэг. Гэмт хэргийн ангиллаас хамааран хэргийн шүүхийн харьяаллыг уг хоёр шүүхэд ялгамжтай тогтооно. Хөнгөн гэмт хэргүүд /*summary offence*-ийг магистратын шүүх хянан шийдвэрлэдэг бол хүнд гэмт хэргүүд /*indictable offence*-ийг “*Crown court*”-д хүлээн авч шийдвэрлэнэ. Харин дунд түвшний гэмт хэргүүд /*either-way offence*/ буюу хулгай, дээрэм, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргүүд гэх мэтчилэн нийгмийн аюулын шинж чанар нь тодорхой нэг тохиолдлоос хамаараад хэлбэлзэж байдаг хэргүүдийг уг хоёр шүүхийн аль аль нь харьяалан хянан шийдвэрлэх боломжтой. Энэ төрлийн гэмт хэргүүдийг аль шүүхэд хянан шийдвэрлэх нь зохимжтой талаар магистратын шүүх шийдвэр гаргах /*allocation decision*/ бөгөөд урьдчилан тогтоосон шалгууруудын дагуу хэргийн нөхцөл байдлыг үнэлж “*Crown court*”-н эрх хэмжээний хүрээнд шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзвэл хэргийг шилжүүлнэ.³¹

²⁹ Gary Slapper and David Kelly, *The English legal system* (6th edition), 2003, page 453.

³⁰ Хууль зүйн ухааны доктор Б.Бат-Орших өөрийн бүтээлдээ тус шүүхийг давж заалдах шатны шүүх хэмээн орчуулсан байна. Энэхүү судалгаанд тус шүүхийн чиг үүргийг давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцуу хүрээнд ойлгуулахаас сэргийлж уг орчуулгыг хэрэглээгүй болно.

³¹ Дунд түвшний гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтооход баримтлах шалгуур нөхцөлүүдийг ИБУИНХУ-ын “Ял шийтгэлийн зөвлөл” /*Sentencing Council*-өөс тогтоосон бөгөөд магистратын шүүх эдгээр шалгууруудад нийцүүлэн хэргийн нөхцөл байдлыг үнэлж шүүхийн харьяаллыг тогтооно. Тухайн хэргийг магистратын шүүхийн эрх хэмжээний хүрээнд хянан шийдвэрлэх боломжтой гэж үзсэн боловч шүүгдэгчид оногдуулж болох ял шийтгэлийн хэмжээ магистратын шүүхээс оногдуулж болох ялын хэмжээнээс хэтэрсэн бол шүүгдэгчийн гэм бурууг тогтоох шүүхийн хэлэлцүүлгийг магистратын шүүхэд явуулж эрүүгийн хариуцлага оногдуулах хуралдааныг *Crown court*-д шилжүүлж болно. Тодруулбал, магистратын шүүхийн хувьд нэг гэмт хэрэгт дээд тал нь 6 сарын хугацаагаар хорих ял оногдуулах эрхийг хуулиар олгосон. Шүүгдэгчид холбогдох хэрэгт үүнээс хүнд ял шийтгэл оногдуулахаар бол гэм буруугийн хуралдаан, эрүүгийн хариуцлагын хуралдааныг салгаж эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг *Crown court*-д шилжүүлдэг байна. <https://www.sentencingcouncil.org.uk/going-to-court/which-court-will-a-case-be->



Хэргийн шүүхийн харьяалал тогтогдсоны дараа магистратын шүүх болон Crown Court-д үндсэн шүүх хуралдааныг үр дүнтэй явуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор тухайн хэрэгт холбогдуулан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал явуулна. Тус улсад шүүгдэгч өөрт хамааралтай хэргийн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрөх нь нээлттэй бөгөөд магистратын шүүх болон Crown Court-н алинд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран энэ эрх үйлчилнэ. Ийнхүү шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах үе шат руу боломжит хугацаанд шууд шилжих процесс өрнөдөг байна.

Урьдчилсан хэлэлцүүлгийн үед шүүх гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн нөхцөлд түүнд хөнгөлөлт үзүүлэхийг шүүгдэгчийн ойлгох хэлбэрээр сануулсан эсэхийг тодруулах, шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрөх эсхүл зөвшөөрөхгүй байх магадлалыг тогтоох, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд түүнийг хүлээн авна. Хэрэв шүүгдэгч урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр гэм буруугаа хүлээн зөвшөөрөөгүй бол дараах нөхцөлүүдийг түүнд ойлгогдох хэлбэрээр тайлбарлаж өгсөн эсэхийг шүүгдэгчээс тодруулна. Үүнд³²:

- Шүүгдэгч шүүх хуралдаанд прокурорын тал хэргийг танилцуулсны дараа нотлох баримт гаргаж өгөх эрх эдлэх;
- Хэрэв шүүгдэгч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол түүний эзгүйд хуралдааныг явуулах;
- Шүүгдэгчийн эзгүйд шүүх хуралдаан явуулах тохиолдолд шүүгч тангарагтны шүүгчдэд түүнийг ирээгүй үндэслэлийг танилцуулах;
- Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан шүүгдэгч шүүхэд хүрэлцэн ирээгүй бол барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох түүнийг баривчилж шийтгэх үндэслэл бүхий гэмт хэрэгт тооцогдохыг сануулна.

Шүүгдэгч гэм буруугаа хүлээсэн эсэхээс хамаарч практикт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хоёр төрөл хэрэгждэг байна. Магистратын шүүхэд шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрөхөө илэрхийлсэн бол “*early first hearing*” буюу шүүгдэгч урьдчилсан хэлэлцүүлгийн үед гэм буруугаа хүлээж, түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах ажиллагаа руу шууд шилжүүлэх процесс хэрэгжинэ. Эсрэг тохиолдолд “*early administrative hearing*” буюу талуудын гаргасан хүсэлтээр, шүүх өөрийн санаачлагчаар цаашид шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй явуулах /*case management*/ зорилго бүхий урьдчилсан хэлэлцүүлгийг явуулна.³³ Харин Crown Court-д эрүүгийн хэрэг бүрд “*plea and trial preparation hearing*” заавал явуулдаг ба үүний зорилго нь шүүгдэгчийн гэм бурууг хүлээн авах, шүүх хуралдааныг үр дүнтэй явуулах бэлтгэлийг хангахад оршино. Энэ хэлэлцүүлгийн явцад шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн бол түүнийг гэм буруутай нь

[heard-in/#:~:text=%E2%80%9CEither%2Dway%E2%80%9D%20offences%20%E2%80%93,bar%20to%20a%20priceless%20antique](#), (Сүүлд үзсэн: 2023.02.04).

³² Criminal Procedure Rules of UK (ИБУИНХУ-ын Эрүүгийн процессын дүрмүүд), 2020, 3.16-3 болон 3.21-2(c) зүйл, <https://www.legislation.gov.uk/ukxi/2020/759/contents> (Сүүлд үзсэн: 2023.02.08).

³³ John Spark, A Practical Approach to Criminal Procedure (11th edition), 2006, page 170.



тогтоогдсонтой адилтган үзэж хамгийн боломжит хугацаанд эрүүгийн хариуцлагын хуралдааныг явуулна.³⁴

Crown Court-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөхийн өмнө ялын тодорхойлолт */indication of sentence/* хүсэх өргөдөл гаргаж болно. Тодруулбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгч өөрт холбогдох хэрэгт гэм буруугаа хүлээсэн тохиолдолд оногдуулж болох ялын дээд хэмжээг тодруулах хүсэлтийг бичгээр шүүхэд гаргах эрхийг Эрүүгийн процессын дүрмээр олгосон. Шүүх заавал шүүгдэгчийн хүсэлтийг хангах үүрэг хүлээхгүй.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс гадна хөнгөн гэмт хэргийг магистратын шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийн бичгээр гаргасан гэм буруугаа сайн дураар хүлээх мэдэгдлийг үндэслэн шүүх түүнийг эзгүйд ял оногдуулах ажиллагааг явуулж болно.³⁵ Энэ тохиолдолд прокурор шүүгдэгчид холбогдох хэргийн үйл баримтыг тогтоосон нотлох баримтуудын товч бүрдэл, бичмэл гэрчийн мэдүүлэг, баримт бичиг болон түүний зарим хэсэг, тэдгээрийн нэгтгэлийг; шүүгдэгчид ял шийтгэл оногдуулахтай холбоотой урьд ял шийтгэгдсэн тухай баримт, шаардлагатай бол шүүгдэгчийн замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн жагсаалт болон шүүгдэгчид ял оногдуулахад хамааралтай түүний хувийн байдлын талаарх мэдээллүүдийг агуулсан мэдэгдэл; шүүхэд дуудан ирүүлэх хуудас; хуульд заасан эрүүгийн процесс ажиллагааны талаарх мэдэгдэл; биечлэн шүүхэд хүрэлцэн ирэхгүйгээр өөрт холбогдох хэргийг хянан шийдвэрлүүлэх процессын зохицуулалтыг тайлбарласан баримт зэргийг шүүгдэгчид хүргүүлнэ.³⁶ Мөн эдгээр баримт бичгүүдийн хуулбар болон шүүгдэгчид хүлээлгэн өгснийг батлах баримтын хамтаар шүүхэд хүргүүлэх бөгөөд шүүхээс шаардлагагүй гэж үзвэл уг ажиллагаанд прокурор оролцохгүй байж болно.

Түүнчлэн дунд түвшний гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал тогтоох хуралдаан */allocation hearing/*-ы үед шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн бол шүүхээс шүүгдэгчийн гэм бурууг тогтоогдсонтой адилтган үзэж ял оногдуулах процессыг эрүүгийн хариуцлагын хуралдаанаар шийдвэрлэхтэй ижил хуулийн зохицуулалтыг хэрэглэж шийдвэрлэдэг.³⁷

Үндсэн шүүх хуралдааны тухайд шүүгдэгч түүнд эрүүгийн хариуцлага оногдуулахаас өмнө аль ч үед гэм буруугаа хүлээн зөвшөөрөх боломжтой боловч шүүх хуралдаан эхлэх үед шүүгдэгчид холбогдох хэргийн прокурор танилцуулсны дараа³⁸ түүнийг гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөх боломжоор дахин хангана. Энэ үед шүүгдэгч гэм буруугаа

³⁴ Мөн тэнд, хуудас 260.

³⁵ Criminal Procedure Rules of UK(ИБУИНХУ-ын Эрүүгийн процессын дүрмүүд), 2020, 24.8 дугаар зүйл Цахим холбоос: <https://www.legislation.gov.uk/ukxi/2020/759/contents> (Сүүлд үзсэн: 2023.02.08).

³⁶ Мөн тэнд.

³⁷ Мөн тэнд, 9.9 дугаар зүйл.

³⁸ Магистартын шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа */summary trial/* эсхүл Crown Court-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа */trial on indictment/*-ны ялгаанаас хамаарч эхний тохиолдолд шүүх хуралдааны эхэнд прокурор шүүгдэгчид холбогдох хэргийн талаар мэдээллийг */information/* танилцуулахад хангалттай бол Crown Court-д хүнд гэмт хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд заавал яллах акт */indictment/* үндэслэж шүүгдэгчийг яллана.



хүлээн зөвшөөрвөл шүүх цаашид талуудаас нотлох баримтуудыг хүлээн авахгүйгээр шүүгдэгчийн гэм бурууг баталж ял оногдуулах процесст шилжинэ.³⁹

Шүүгдэгч сайн дураараа гэм буруугаа хүлээн зөвшөөрөх процесс ИБУИНХУ-ын шүүхийн практикт нэлээд өргөн хэрэглэгддэг. 2014 онд тус улсад 1,215,695 хүн ял шийтгүүлснээс 86,297 нь “Crown Court”-н шийдвэрээр үлдсэн 1,129,398 нь магистратын шүүхийн шийдвэрээр ял шийтгүүлсэн байна. “Crown Court”-н шийдвэрээр ял шийтгэгдсэн этгээдүүдийн 90 хувь нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг шатанд гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрчээ.⁴⁰

Тус улсын эрүүгийн бодлогод шүүгдэгчийг аль болох эрт шатанд өөрийн гэм бурууг сайн дураар хүлээх явдлыг дэмждэг бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль үе шатанд гэм буруугаа хүлээснээс хамаараад ял шийтгэл хөнгөрүүлэх хэмжээ нь өөр өөр байна. “Гэм буруугаа хүлээсэн этгээдэд оногдуулах ялыг хөнгөрүүлэх” журмыг “Ялын зөвлөл” /*Sentencing Council*-өөс 2017 онд шинэчлэн баталсан. Үүнд зааснаар гэм буруугаа сайн дураараа хүлээх процесс нь эрт үе шатад илрэх тусмаа илүү үр ашигтай. Энэ нь юун түрүүнд хохирогчид учрах гэмт хэргийн сөрөг үр дагаврыг бууруулах; гэрч, хохирогчийг мэдүүлэг өгөх ажиллагаанд оролцохоос хамгаалах; мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдаанд зориулах зардал, цаг хугацааг хэмнэх нийтийн ашиг сонирхолд нийцдэг гэжээ.⁴¹

Шүүхээс гэм буруугаа сайн дураараа хүлээсэн шүүгдэгчид ял оногдуулахдаа дараах хүчин зүйлсийг харгалзаж үзнэ. Үүнд:

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль үе шатанд шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрөх хүсэл зоригоо илэрхийлсэн болох;
2. Ийнхүү хүсэл зоригоо илэрхийлсэн нөхцөл байдал гэх мэт.

Хэрэв шүүгдэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамгийн эхний үе шатад өөрийн гэм бурууг сайн дураар хүлээн зөвшөөрсөн бол түүнд оногдуулах ялыг 1/3 хүртэлх хэмжээгээр хөнгөрүүлж болох бөгөөд үүнээс хойших хугацаанд энэ хэмжээ 1/4-өөс 1/10 хүртэл буурч болно.

Шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөх төрлүүд:

1.Хамтран гэмт хэрэг үйлдэгчид- Гэмт хэрэг хамтран үйлдэгчдийн аль нэг нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуралдааныг хойшлуулж, шүүгдэгчид цагдан хорих, эсхүл барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авч болно. Ийнхүү эрүүгийн хариуцлага хүлээлгэх процессыг хойшлуулах эсэх нь шүүгчийн бүрэн эрхийн хүрээнд хамаарна. Гэмт хэрэг хамтран үйлдэгчдийн аль нэг нь гэм буруугаа хүлээснээр хэрэгжих процессын давуу тал нь

³⁹ Criminal Procedure Rules of UK(ИБУИНХУ-ын Эрүүгийн процессын дүрмүүд), 2020, 24.7 болон 25.4 зүйл, <https://www.legislation.gov.uk/ukxi/2020/759/contents>, (Сүүлд үзсэн: 2023.02.04).

⁴⁰ Цахим эх сурвалж: <https://www.sentencingcouncil.org.uk/wp-content/uploads/Consultation-Resource-Assessment-Reduction-in-sentence-for-a-guilty-plea.pdf>, (Сүүлд үзсэн: 2023.02.04).

⁴¹ Reduction in sentence for guilty plea by Sentencing Council (Гэм буруугаа хүлээснээр оногдуулах ял шийтгэлийг хөнгөрүүлэх удирдамж), 2017, <https://www.sentencingcouncil.org.uk/overarching-guides/crown-court/item/reduction-in-sentence-for-a-guilty-plea-first-hearing-on-or-after-1-june-2017/>, (Сүүлд үзсэн: 2023.02.04).



шүүгч гэм буруугаа хүлээгээгүй шүүгдэгчийн хэргийг хэлэлцэх явцад хэргийн үйл баримт, нөхцөл байдалтай дэлгэрэнгүй танилцах боломж олгодог байна.

2. Хоёрдмол утга илэрхийлэх /ambiguous plea/- Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай талаараа тодорхой бус хоёрдмол агуулга бүхий илэрхийлэл гаргаж болно. Жишээ нь: “Би тухайн эд зүйлсийг авсандаа буруутай. Гэхдээ тэдгээрийг хулгайлагдсан байсныг би мэдээгүй” эсхүл, “Би тэднийг хулгайлагдсан эд зүйлс гэж бодсон. Гэхдээ хэн ч надад тийм гэдгийг хэлээгүй” гэх мэтчилэн тодорхойгүй утга илэрхийлж болно. Энэ тохиолдолд шүүгч түүнд буруутгагдаж буй гэмт хэргийн элементийг дахин тайлбарлан өгөх замаар гэм бурууг тодруулах оролдлого хийнэ. Ингэснээр шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол түүнийг хурдавчилсан процессоор буюу шууд эрүүгийн хариуцлагыг шийдвэрлэх ажиллагаа руу шилжүүлэх процесс хэрэгжинэ. Харин шүүгдэгч тодорхойгүй, хоёрдмол хариулт өгсөн хэвээр байх тохиолдолд түүнийг гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан гэж үзнэ.

3. Дарамтад орсны улмаас гэмт хэрэг үйлдсэн гэм буруу хүлээх /involuntary pleas/- Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа өөрөө хүлээх процесс нь зөвхөн түүний чөлөөт хүсэл зориг буюу бүрэн сайн дурын үндсэн дээр хэрэгжсэн байх шаардлагатай ба зөвхөн шүүгдэгч өөрийн биеэр гэм буруугаа хүлээх хүсэл зоригоо илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд дарамтад орж гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, түүнийг гэм буруугаа хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх сонголтыг үнэнчээр хийхэд саад болохуйц нөхцөл байдалд байсан бол гэм буруу хүлээсэн процесс хүчингүй. Шүүгдэгч энэ талаар давж заалдах гомдол гаргавал шүүх уг процессыг хүчингүй болгож дахин шүүх хурал явуулах шийдвэр гаргана.⁴²

ИБУИНХУ-д *Turner* болон *Goodyear*-н хэргүүдээр шүүгч болон шүүгдэгчийн өмгөөлөгчийн зүгээс ирж болох дарамтуудаас шүүгдэгчийг хамгаалах талаарх жишиг тогтоогджээ.

1970 онд шийдвэрлэгдсэн “Turner”-н хэрэг⁴³: Шүүгдэгч Т хулгайн гэмт хэргийн гэм буруугаа хүлээхээс татгалзсан байна. Прокурорын дуудсан гэрчүүд мэдүүлэг өгч дууссаны дараа шүүгдэгч өмгөөлөгч болон хууль зүйн туслалцаа үзүүлэгч /*solicitor*/-тэйгээ удаан хугацааны туршид ярилцжээ. Түүний өмгөөлөгч шүүгчтэй тусдаа ерөөнд уулзсаны эцэст эргэж ирээд Т-д хандан “хэрэв тэрээр гэм буруугаа хүлээхээс татгалзсан хэвээр үлдэж шүүхээс түүнийг гэм буруутайг тогтоовол хорих ял авах өндөр магадлалтай, харин гэм буруугаа хүлээвэл торгох болон бусад хорихоос өөр төрлийн ял шийтгэгдэж болох” талаар хэлжээ. Т өмгөөлөгчөө шүүгчтэй ярилцсан яриагаа өөрт нь дамжуулж байна гэж ойлгон гэм буруугаа хүлээсэн боловч үнэн хэрэгтээ өмгөөлөгч зөвхөн өөрийн бодлыг илэрхийлсэн байв. Давж заалдах шатны шүүх Т-г буруутгасан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шүүх хурал явуулах шийдвэр гаргажээ. Энэ хэрэг шүүгчийн зүгээс ирж болох дарамтаас шүүгдэгчийг хамгаалах зарчмыг тогтоосон жишиг шийдвэр болжээ.

2005 онд шийдвэрлэгдсэн “Goodyear”-н хэрэг⁴⁴: Шүүгдэгчийн өмгөөлөгч “прокурорын үндэслэл маш хүчтэй байгаа учир яллаж буй гэмт хэргийг үйлдсэн эсэхээс үл хамааран гэм

⁴² John Spark, *A Practical Approach to Criminal Procedure* (11th edition), 2006, page 273.

⁴³ Мөн тэнд.

⁴⁴ Мөн тэнд.



буруугаа хүлээн зөвшөөрөх нь түүний хувьд хамгийн боломжит хувилбар” хэмээн шүүгдэгчид хэлжээ. Өмгөөлөгчийн үүрэг бол өөрийн үйлчлүүлэгчид хандан өгч чадах хамгийн сайн зөвлөгөөгөө өгөх мөн. Үүндээ эсрэг талын байр суурь хэр хүчтэй байгаа талаар, гэмт хэргийн шинжээс хамааран тулгарч болох хүндрэлүүд, шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр илүү хөнгөн ял шийтгүүлж болох талаар дурдаж болох төдийгүй шүүгчээс оногдуулж болох ял шийтгэлийн талаарх өөрийн үзэл бодлыг тодорхойлж болно. Гэсэн хэдий ч шүүгдэгч гэм буруугаа өөрийн чөлөөт хүсэл зоригийн үндсэн дээр, үнэн санаанаас хүлээх ёстой талаарх шаардлагыг тус шийдвэрээр тогтоожээ.

Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн шийдвэрээс татгалзах: Шүүгдэгч гэм буруугаа хүлээсэн шийдвэрээсээ татгалзах тохиолдолд эрүүгийн хариуцлага оногдуулах ажиллагаанаас өмнө аль ч үед шүүхэд бичгээр хүсэлт гаргана. Хүсэлтдээ шүүх гэм буруугаа хүлээн зөвшөөрөхөөс татгалзах хүсэлтийг хүлээж авахгүй байх нь яагаад шударга ёсонд үл нийцэх тухай тайлбарлах, шүүгдэгчийн зүгээс дуудахыг хүсэж буй гэрч, бусад нотлох баримтууд болон өмгөөлөгчөөс авсан хууль зүйн туслалцааны нууцлалыг цуцлах эсэхийг дурдсан байх ёстой.⁴⁵ Хүсэлтийг хүлээн авах эсэх нь шүүгчийн эрх хэмжээнд хамаарах ба шүүгч нэн тэргүүн шүүгдэгч яллах ажиллагааны мөн чанарыг тодорхой ойлгосон эсэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрөхдөө үнэнчээр шийдвэр гаргасан эсэхийг нягталж үзнэ.⁴⁶

“Plea agreement” буюу гэм буруугийн тохиролцоо: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад яллагдагч, прокурор хэргийн үйл баримтын талаар тохиролцоонд хүрч болно. Яллагдагч прокурорын тогтоосон хэргийн үйл баримт, гэмт хэргийн зүйлчлэлийг бүхэлд нь хүлээн зөвшөөрч тохиролцоонд хүрч чадвал процесс ердийн журмаар үргэлжлэх ба түүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын асуудлыг өмнө дурдсанчлан түргэвчилсэн процессоор шийдвэрлэн явуулна. Энэхүү тохиролцоог **plea agreement** буюу гэм буруугийн тохиролцоо гэх бөгөөд АНУ-д хэрэгждэг *plea bargaining* процессоос бага зэрэг ялгаатай. ИБУИНХУ-н прокурор шүүхэд ялын санал гаргах эрхгүй бөгөөд 2015 онд батлагдсан Эрүүгийн процессын практик ажиллагааны удирдамж /*Criminal Practice Direction*/-д зааснаар ээдрээ төвөгтэй, хүнд залилах гэмт хэрэгт прокурор, яллагдагч гэм буруугийн тохиролцоонд хүрэхийн сацуу ялын талаар харилцан тохирсон санал гаргаж болох боловч үүнд талууд ялын талаар нарийвчлан тодорхой тохиролцсон байхыг хориглодог. Зөвхөн “Ял шийтгэлийн удирдамж”-ийн холбогдох заалтыг л тусгана.

Шүүгч гэм буруугийн тохиролцоог хүлээж авч хянах, уг тохиролцоо шударга ёсны шалгуурт нийцсэн эсэхийг нягтлах, баталгаажуулах нь түүний эрх хэмжээний хүрээнд хамаарна. Шүүгчийн хяналт, тохирох ял шийтгэл оногдуулах бололцоог хангах үүднээс тохиролцоонд хүрэх процесс, хэргийн үйл баримтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шүүхэд гаргаж өгөх шаардлагатай. Үүнд наад зах нь дараах баримт бичгүүдийг багтаана⁴⁷:

1. Гэм буруугийн тохиролцоо;

⁴⁵ Criminal Procedure Rules of UK (ИБУИНХУ-ын Эрүүгийн процессын дүрмүүд), 2020, 24.10 болон 25.5 дугаар зүйл, <https://www.legislation.gov.uk/ukxi/2020/759/contents>. (Сүүлд үзсэн: 2023.02.04).

⁴⁶ John Spark, A Practical Approach to Criminal Procedure (11th edition), 2006, page 276.

⁴⁷ Criminal Practice Direction of UK (ИБУИНХУ-ын Эрүүгийн процессын практик ажиллагааны удирдамж), 2015, В.11 дугаар зүйл, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/924048/crim-practice-directions-VII-sentencing-2015.pdf. (Сүүлд үзсэн: 2023.02.09).



2. Ялын санал;
3. Тохиролцоонд хүрэх явцад прокуророос шүүгдэгчид гаргаж өгсөн бүхий л материалууд;
4. Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл гэх мэтчилэн яллагдагчаас гаргаж өгсөн бусад хамаарал бүхий материалууд;
5. Тохиролцох процессын үед талуудын уулзсан бол уулзалт үргэлжилсэн хугацаа, харилцсан захидал гэх мэт.

Шүүгдэгч хэргийн үйл баримтыг прокурорын тогтоосноос өөр нөхцөлөөр тохиролцож чадсан бол үүнийг *“agreed basis of plea”* хэмээн нэрлэх бөгөөд энэ тохиолдолд уг тохиролцоо нотлох баримтуудын агуулгатай бүрэн, зохистой нийцсэн эсэх, шударга ёсны шалгуурыг хангасан эсэхийг шүүгч хянаж батална.⁴⁸ Талуудын тохиролцоог шүүгч заавал хүлээн зөвшөөрөх үүрэггүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт нотлох баримт шаардаж болно. Шүүгч ийнхүү хяналт тавих явцад шүүгдэгчийн гэм буруугаа хүлээсэн үндэслэл буюу тохиролцоонд хүрсэн хэргийн үйл баримтыг хүчингүй болгохдоо зайлшгүй шүүгдэгчийг байлцуулж шүүхийн хэлэлцүүлэг явуулна. Тохиролцсон үйл баримт худал болох нь илтэд тодорхой, эсхүл шүүгдэгч өөрөө хэлэлцүүлэгт оролцох эрхээсээ татгалзсан тохиолдолд хэлэлцүүлэг явуулахгүй байж болно.⁴⁹

Нөгөө талаас тохиролцоонд хүрч чадаагүй буюу прокурор яллагдагчийн хэргийн үйл баримтын талаар яллагдагчийн гаргасан саналыг хэсэгчлэн болон бүрэн хүлээн зөвшөөрөөгүй бол шүүх талуудын байр суурийг бичгээр хүлээн авч шүүхийн хэлэлцүүлэг явуулж болно. Энэ хэлэлцүүлгийн үеэр талууд өөрсдийн нотлох баримтуудыг танилцуулж, үйл баримтыг нотлох үүрэг, нотолгооны стандартыг үндсэн шүүх хуралдааны адил баримтална.⁵⁰

ТАВ. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-ын Үндсэн хуулийн зургаадугаар зүйлд зааснаар хүн бүр хурдан шуурхай, нээлттэй шүүх хуралдаанд тангарагтны шүүгч нарын хамтаар гэм буруутай эсэхээ тогтоолгон шүүлгүүлэх эрхийг баталгаажуулсан. Үүний дагуу АНУ-ын Холбооны Эрүүгийн процессын дүрмүүд (*Federal Rules of Criminal Procedure, 2020*) дөрөвдүгээр бүлгийн 11 дүгээр зүйлд шүүгдэгч гэм буруугаа хүлээж ял тохиролцох (*plea bargaining*) тухай зохицуулалтыг хуульчилсан ба энэ нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх хялбаршуулсан журамд тооцогдоно. 2010 онд хийсэн судалгаагаар тус улсад нийт гэмт хэргийн 97% нь гэм буруугаа хүлээх хэлцлээр шийдэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, ихэнх шүүгдэгч тангарагтны шүүх хурал хийлгэх эрхээсээ татгалзан шүүгчийн өмнө гэм буруугаа хүлээдэг. Шүүгдэгч гэм буруугаа шууд хүлээснээр тангарагтны шүүгч нарыг шүүх хуралдаанд оролцуулж шүүгдэгчийг гэм буруутайг нотлох шаардлага гарахгүй. Энэ нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цаг хугацаа болон зардлыг хэмнэх төдийгүй шүүгдэгчийн ялыг хөнгөрүүлэх, хөнгөн ял оногдуулах үндэслэл болдог. Тухайлбал, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн

⁴⁸ Мөн тэнд, В.7 дугаар зүйл.

⁴⁹ Мөн тэнд, В.11 дугаар зүйл.

⁵⁰ Мөн тэнд, В.12 болон В.13 дугаар зүйл.



этгээдэд шүүхээс нийт гурван төрлийн хөнгөн ял оногдуулах байсан бол гэм буруугаа хүлээх хэлцлээр прокурор түүнд хоёр ялыг нь хасаж хөнгөрүүлж болох юм.⁵¹

АНУ-ын Холбооны Эрүүгийн процессын дүрмүүдийн 11 дүгээр зүйлийн (а) хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу шүүгдэгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн гэм бурууг хүлээн зөвшөөрөх, хүлээн зөвшөөрөхгүй байх, эсхүл мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу аль нэг талын байр суурь илэрхийлэхээс татгалзах (*nolo contendere*)⁵² хүсэлт гаргах шийдвэрүүдээс аль нэгийг нь гаргаж болно. Шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрөх хүсэлт гаргасан нь яллах талтай ялын тохиролцоо /хэлцэл/ байгуулах үндэс болох бөгөөд хэлцэл байгуулах процесст зөвхөн яллах тал, шүүгдэгчийн өмгөөлөгчид оролцоно. Холбооны Эрүүгийн процессын дүрэм болон АНУ-ын Хуульчдын холбооноос 1997 онд баталсан “Эрүүгийн эрх зүйн стандарт: Ял тохиролцох ажиллагаа” (*Standards for Criminal Justice: Pleas of Guilty*)-д энэхүү хэлцэл байгуулах хэлэлцүүлэгт шүүгч оролцохыг хориглосон.⁵³ Энэ нь гэм буруугаа хүлээх процесс зөвхөн шүүгдэгчийн сайн дурын үндсэн дээр буюу шүүгдэгчийн бие даасан шийдвэр байх зарчимд үндэслэдэгтэй холбоотой. Хэлэлцүүлэгт оролцохыг хязгаарлаад зогсохгүй шүүгч үгээрээ болон биеэ авч явах байдлаараа шүүгдэгч, түүний өмгөөлөгчид гэм буруугаа хүлээх, гэм буруугийн хэлцэл хийх ёстой мэтээр ойлголт төрүүлэхийг хориглоно.⁵⁴ Үүний адилаар шүүгдэгчийн өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ зохих ёсоор мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй, хэргийг судлаагүй байхад шүүгдэгчид гэм буруугаа хүлээн зөвшөөрөхийг санал болгож болохгүй. Харин гэм буруугийн хэлцлийг зөвхөн шүүгдэгчийн зөвшөөрлөөр дүгнэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрөх, тодорхой байр суурь илэрхийлэхээс татгалзах хүсэлт нь эцсийн дүндээ зөвхөн шүүгдэгчийн шийдвэрээр гарсан эсэхийг баталгаажуулах үүрэгтэй.⁵⁵

Шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн бол нээлттэй шүүх хуралдааны үеэр шүүгч шүүгдэгчээс дараах асуултуудыг асууж, ойлгосон эсэхийг тодруулах ёстой. Үүнд:⁵⁶

(А) хэрэв худал мэдүүлэг өгсөн бол шүүгдэгчийн тангараг өргөсөн аливаа мэдэгдлийг яллах тал шүүгдэгчийн эсрэг ашиглах эрх;

⁵¹James E. Novak. (2022). *Plea Bargaining in Misdemeanor Cases*. <https://www.novakazlaw.com/plea-bargaining-in-misdemeanor-cases.html>. (Сүүлд үзсэн: 2023.02.10).

⁵² Латин хэлнээс орчуулбал “Би маргахыг хүсэхгүй байна” буюу шүүгдэгч мэдүүлэг өгөхөөс татгалзах хуулийн нэр томъёо юм.

⁵³ АНУ-ын Холбооны Эрүүгийн процессын хуулийн 11.(с)-1 дэх заалт, Эрүүгийн эрх зүйн стандарт: Гэм буруугаа хүлээх ажиллагааны 14-3.3 дахь хэсгүүдэд тус тус шүүхийн оролцоог хязгаарлах, зөвшөөрөх үндэслэлүүдийг заасан байна. Гэм буруугаа хүлээх ажиллагааны стандарт дүрмүүдэд зааснаар талуудын хүсэлтээр гэм буруугийн хэлцлийн агуулгыг шүүх хүлээж авах боломжтой эсэх, ямар ял шийтгэл оногдуулах талаарх тодруулга авах зорилгоор шүүгчийг оролцуулж болно гэжээ. Үүнээс бусад байдлаар шүүгч хэлцэлд хүрэх ажиллагаанд оролцохыг хориглоно.

⁵⁴ Standards for Criminal Justice: Pleas of Guilty (Эрүүгийн эрх зүйн стандарт: Гэм буруугаа хүлээх ажиллагаа), 1997, 14-3.3 дахь хэсэг, https://www.americanbar.org/groups/criminal_justice/publications/criminal_justice_section_archive/crimjusst_standards_guiltypleas_blk/. (Сүүлд үзсэн: 2023.02.09).

⁵⁵ Мөн тэнд, 14-3.2 дахь хэсэг.

⁵⁶ Federal Rules of Criminal Procedure (АНУ-ын Холбооны Эрүүгийн процессын дүрмүүд), 2020, 11 дүгээр зүйл, https://www.uscourts.gov/sites/default/files/federal_rules_of_criminal_procedure_-_december_2020_0.pdf. (Сүүлд үзсэн: 2023.02.09).



- (Б) өөрийгөө гэм буруугүй гэж мэдүүлэх эрх, эсхүл аль хэдийн мэдүүлсэн бол энэ хүсэлтээ буцаахгүй байх;
- (В) тангарагтны шүүх хуралдаанд оролцох эрх;
- (Г) шүүх хуралдаанд болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад бүх шатанд өмгөөлөгчөөр төлөөлүүлэх, шаардлагатай бол шүүхээс өмгөөлөгч томилуулах эрх;
- (Д) шүүх хуралдаанд гэрчтэй нүүрэлдүүлэх, өөрийгөө албадан гүтгэхээс хамгаалах, мэдүүлэг өгөх, нотлох баримт гаргах, гэрчийг дуудан ирүүлэх эрх;
- (Е) шүүх гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн эсвэл мэдүүлэг өгөхөөс татгалзах хэлцлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд шүүгдэгч дээрх эрхүүдээс хязгаарлагдах;
- (Ё) шүүгдэгчийн хэлцлээр буруутгагдаж байгаа хэрэг бүрийн агуулга, шинж чанар;
- (Ж) хорих, торгууль, хяналтад суллах хугацаа зэрэг байж болох хамгийн дээд боломжит шийтгэл;
- (З) заавал биелүүлэх хамгийн бага шийтгэл;
- (И) аливаа эрхийг хязгаарлах, дуусгавар болгох;
- (Й) нөхөн төлбөр шаардах шүүхийн бүрэн эрх;
- (К) тусгай үнэлгээ ногдуулах шүүхийн үүрэг;
- (Л) ял тогтоолгохдоо шүүхийн хэрэглэгдэх ялын зааврын хүрээг тооцох, уг хязгаараар, ял оногдуулах 18 U.S.C. § 3553(a)⁵⁷ удирдамжийн дагуу гарах боломжит нөхцөл;
- (М) ялыг давж заалдах мөн шинэ хэргээр хүчингүй болгох зэрэг эрхүүдээс хязгаарлах хэлцлээр тохиролцооны зүйл заалтууд;
- (Н) хэрвээ гэм буруутай нь тогтоогдвол АНУ-ын иргэн биш шүүгдэгчийг АНУ-аас гаргаж, иргэний харьяаллаас нь татгалзаж, цаашид АНУ-д нэвтрүүлэхийг хориглож болно.

Шүүгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөх хүсэлтийг хүлээн авахдаа нэн тэргүүнд талууд ялын тохиролцоонд хүрч чадсан эсэхийг шалган тогтоохгүйгээр хүлээн авч болохгүй. Талууд тохиролцоонд хүрч хэлцэл байгуулж чадсан бол түүний агуулга, нөхцөлүүдийг нээлттэй тавихыг шаардах эрхтэй. Энэхүү талуудын байгуулсан хэлцэлд шүүгч шийдвэрээ заавал нийцүүлэх шаардлагагүй бөгөөд хэлцлээр тохирсон хэргийн зүйлчлэл болон оногдуулах ял шийтгэлийг хүлээн авах эсэхийг шүүгч бие даан шийдвэрлэнэ. Энэ талаарх мэдээллийг буюу гэм буруугийн хэлцлийг шүүхийн эцсийн шийдвэрт тусгахгүй байж болохыг шүүгдэгчид анхааруулж, гэм буруугаа хүлээн зөвшөөрөх

⁵⁷ Ялыг тогтооход авч үзэх нөхцөлүүдтэй холбоотой уг удирдамжид тухайн ял нь хангалттай хэмжээнд, гэхдээ шаардлагатай хэмжээнээс хэтрэхгүй байхаар ногдуулах ёстой гэсэн байдаг.



хүсэлтээсээ татгалзахыг зөвшөөрч болно. Шүүгдэгч ялын тохиролцоогоор дамжуулан гэм буруугаа хүлээсний дараа шүүх уг тохиролцоогоор тогтсон гэмт хэргийн зүйлчлэл болон ял шийтгэлийг шүүхийн эцсийн шийдвэрт тусгахгүйгээр шийдвэрлэсэн бол дараах тохиолдлуудад шүүгдэгч гэм буруугаа хүлээсэн хүсэлтээсээ татгалзаж болно. Үүнд⁵⁸:

1. Шүүгч өмнө тохиролцсон зүйлчлэл болон ялтай бүхэлд нь, юм уу урьдчилан санал нэгдсэн байсан;
2. Хэрэв талууд хожим нь шүүх тохиролцоонд заасан зүйлчлэл болон ялыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн шийдвэрээсээ татгалзах эрхтэй талаарх болзолт нөхцөлтэйгөөр гэм буруугаа хүлээсэн.

Харин эрүүгийн хариуцлага оногдуулахаас өмнөх шатанд шударга бөгөөд зүй ёсны үндэслэлээр шүүгдэгчийн гэм буруугаа хүлээсэн хүсэлтээсээ татгалзах татгалзлыг хүлээж авна. Ийнхүү татгалзлыг хүлээн авахдаа шүүгдэгчийн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүсэлтэд найдсан яллах талын хувьд учирч болох аливаа хохирлыг дэнсэлж үзэх шаардлагатай.⁵⁹

⁵⁸ Standards for Criminal Justice: Pleas of Guilty (Эрүүгийн эрх зүйн стандарт: Гэм буруугаа хүлээх ажиллагаа), 1997, 14-3.3 дахь хэсэг, https://www.americanbar.org/groups/criminal_justice/publications/criminal_justice_section_archive/crimjusst_standards_guiltypleas_blk/, (Сүүлд үзсэн: 2023.02.09).

⁵⁹ Standards for Criminal Justice: Pleas of Guilty (Эрүүгийн эрх зүйн стандарт: Гэм буруугаа хүлээх ажиллагаа), 1997, 14-2.1 дахь хэсэг, https://www.americanbar.org/groups/criminal_justice/publications/criminal_justice_section_archive/crimjusst_standards_guiltypleas_blk/, (Сүүлд үзсэн: 2023.02.09).



ДҮГНЭЛТ

Судалгааны явцад ОХУ, БНХАУ, ХБНГУ, ИБУИНХУ болон АНУ зэрэг нийт 5 орны шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрснөөр хэрэгжих эрүүгийн процесс ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлог, нийтлэг ба ялгаатай шинжүүдийг; ХБНГУ, ОХУ болон БНХАУ-ын шүүхийн жишиг шийдвэрийн хамтаар харьцуулан судаллаа. Судалгааны үр дүнгээс харахад, юун түрүүнд шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээснээр хэрэгжих тусгай процессыг эрх зүйн тогтолцоондоо нэвтрүүлсэн нь улс орнуудад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай явуулах, зардал хэмнэх, хохирогчийн эрхийг хамгаалах нийтлэг зорилгод чиглэж байна. Гагцхүү хэрэгжүүлэх процесс, шийдвэрлэх арга хэлбэр, талуудын хооронд тохиролцоо байгуулах боломжтой эсэх, түүнд оролцогч талууд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль үе шатанд хэрэгжүүлэх боломжтойгоос хамаараад харилцан адилгүй өөр өөрсдийн онцлог бүхий зохицуулалтын механизмыг боловсруулжээ.

Энэхүү процесс нь тохиролцоонд үндэслэн явагдах боломжтой болон тохиролцоонд үндэслэх боломжгүй гэсэн хоёр хэсэгт улс орнуудыг хувааж болохоор байна. Судалсан улс орнуудаас ОХУ-д тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад яллах болон шүүгдэгч тал гэм буруу, ялын талаар тохиролцоонд хүрэх тухай зохицуулалтыг хуульчлаагүй. Бусад буюу БНХАУ, ХБНГУ, ИБУИНХУ, АНУ зэрэг орнуудад тохиролцооны аргыг өөр өөрсдийн эрх зүйн системийн онцлогт нийцүүлэн хууль тогтоомжийн хүрээнд тогтоожээ. Өөрөөр хэлбэл, эрх зүйн глобалчлалын нөлөөллөөр жишгийн эрх зүйн орнуудаас үүсэлтэй “*plea bargain*” буюу гэм буруугийн хэлцэл байгуулах/ял тохиролцоо аргыг аль ч эрх зүйн системийн орнууд өөрийн тогтолцоонд нийцүүлэн нутагшуулах чиг хандлага бий болсон байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тохиролцоо байгуулахыг зөвшөөрсөн орнуудын эрх зүйн зохицуулалт нь дотроо тохиролцооны талаарх ойлголт, түүний агуулга, оролцогч талуудаараа ялгаатай байна. Эдгээр ялгаа, онцлогуудаас хамааруулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад байгуулах тохиролцоог нэгдүгээрт, тохиролцооны агуулгаар гэм буруугийн хэлцэл болон ял тохиролцоо байгуулах; хоёрдугаарт, шүүхийн оролцоотой болон оролцоогүй хэмээх ангиллуудад хувааж болохоор байна. Тодруулбал, ХБНГУ-аас бусад орнуудад шүүгдэгчийн гэм буруу болон түүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын асуудлаар тохиролцоо ажиллагаанд шүүгч оролцдоггүй буюу тохиролцоо ихэвчлэн шүүхийн өмнөх шатанд прокурор болон шүүгдэгчийн хооронд байгуулагддаг байна. Жишээлбэл, АНУ болон ИБУИНХУ-д яллах тал болон шүүгдэгч хэргийн үйл баримт, гэмт хэргийн зүйлчлэлийн талаар харилцан тохиролцож гэм буруугийн хэлцэл байгуулах хэлэлцүүлэгт шүүгч хөндлөнгөөс оролцохыг хатуу хориглодог. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээх асуудал гагцхүү шүүгдэгчийн сайн дурын үндсэн дээр буюу чөлөөт хүсэл зориг, бие даасан шийдвэрт үндэслэж гарах ёстой гэсэн зарчмыг чанд баримталдагтай холбоотой байна. Харин ХБНГУ-д эрүүгийн хэргийн тохиролцоо шүүхийн шатанд сонгодог хэлбэрээрээ хэрэгждэг гэж үздэг бөгөөд шүүгч прокурор болон шүүгдэгчтэй шүүх хуралдааны явцад шүүгдэгчийн гэм буруу, ял шийтгэл, хор уршгийн асуудлаар тохиролцоо байгуулах онцлог аргыг хэрэглэдэг.



Дээрхээс үүдэн тохиролцоонд оролцогч талуудын ялгаа гарч ирж байна. Өөрөөр хэлбэл, ХБНГУ-ын зохицуулалтад үндэслэн тохиролцоонд шүүгч, прокурор, шүүгдэгч гурван тал оролцох, эсхүл зөвхөн шүүгдэгч болон прокурорын хооронд тохиролцоо явагдаж болно.

Өмнө дурдсанчлан эрүүгийн хэргийн талаар тохиролцож болох зүйл буюу тохиролцооны агуулгын хувьд гэм буруугийн болон эрүүгийн хариуцлагын гэсэн хоёр хэсэгт хуваагдана. Гэм буруугийн талаар тохиролцоонд гэмт хэргийн үйл баримт, зүйлчлэлийн асуудал гол төлөв багтаж байх бол эрүүгийн хариуцлагын талаарх тохиролцоонд ялын хэмжээг нарийн тодорхой тогтоохоос илүүтэй оногдуулж болох үндсэн ялын дээд доод хэмжээ, нэмэгдэл ял, тэнсэх боломж зэргийг багтааж байна. Тухайлбал, зөвхөн БНХАУ-д прокурор сэжигтэнтэй гэм буруу, оногдуулах эрүүгийн хариуцлага, үүн дундаа үндсэн болон нэмэгдэл ял, тэнсэх арга хэмжээний талаар нарийвчлан тодорхой тохиролцож, шүүхэд ялын санал гаргах эрхтэй байдаг. ХБНГУ, ИБУИНХУ-д прокурор тохиролцоо/хэлцэлд шүүгдэгчид оногдуулах эрүүгийн хариуцлагын асуудлыг нарийвчлан тохиролцож шүүхэд санал гаргах эрхгүй бөгөөд зөвхөн ялын дээд болон доод хэмжээ, ял шийтгэлийн удирдамжийн холбогдох зохицуулалтыг дурдах хүрээнд ял тохиролцох ойлголт хязгаарлагдана. ХБНГУ-д шүүгчээс шүүгдэгчтэй ялын талаар нарийвчлан тохиролцох явдлыг хууль тогтоогч хүлээн зөвшөөрдөггүй ажээ.

Ийнхүү гэм буруу болон эрүүгийн хариуцлагын асуудлаар шүүхийн өмнөх шатанд талуудын байгуулсан тохиролцоо /хэлцэл/-г шүүх заавал баримтлах үүрэггүй болохыг нийтлэг хуульчилжээ. Тохиролцооны бодитой байдал буюу шүүгдэгчийн үйлдэл гэмт хэргийн шинжийг хангах эсэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн нь хэргийн бодит үйл баримттай тохирч байгаа эсэх, шударга ёсны шалгуурт нийцсэн эсэхийг шүүгч нягталж тохиролцоог баталгаажуулахаас татгалзах, тохиролцооноос өөрөөр хэргийг шийдвэрлэх нь шүүгчийн бүрэн эрхийн хүрээнд хамаарна. Нөгөө талаас тохиролцоог хүлээн авахаас татгалзсанаар уг тохиролцоонд үндэслэн шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч хэргийг хялбаршуулсан буюу хурдавчилсан журмаар хянан шийдвэрлэх процесс мөн цуцлагдана.

Энэ талаар ИБУИНХУ-ын эрүүгийн процессын дүрэмд шүүгдэгч болон прокурор хэргийн үйл баримт дээр тохиролцох аргыг харьцангуй уян хатан хуульчилж өгсөн байна. Шүүгдэгч прокурорын яллах актад тусгасан хэргийн үйл баримттай заавал бүхэлд нь санал нэгдэх албагүй бөгөөд хэсэгчлэн, эсхүл арай хөнгөн хэргийн үйл баримт, зүйлчлэлийн талаар гаргасан шүүгдэгчийн саналыг прокурортой тохиролцох боломж нээлттэй. Гагцхүү талуудын хооронд уг асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд шүүгч тохиролцох ажиллагаанд оролцож, нотлох баримт шалгах, гэрч дуудах замаар шүүхийн хэлэлцүүлэг явуулж талуудын маргааныг шийдвэрлэх боломжтой.

Ерөнхийдөө эрүүгийн хэрэг дэх тохиролцооны талаарх ойлголтын онцлог, түүнийг дагаж хэрэгжих процесс нь улс орнуудад эх газрын болон жишгийн эрх зүйн системээс хамааран ялгаатай байна. Эх газрын зүйн системтэй орнууд буюу ОХУ, ХБНГУ, БНХАУ-уудад хэргийн бодит байдлыг тогтоох зарчмын үүднээс шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн өргөдөл болон тохиролцоог шүүгч хүлээн авахад баримтлах чухал урьдчилсан нөхцөл нь прокурор мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд шүүгдэгчид холбогдох хэрэг, түүний гэм бурууг хэлбэрэлтгүй тогтоосон байхыг шаардана. Харин ИБУИНХУ, АНУ



зэрэг аливаа эрх зүйн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа мэтгэлцэх зарчимд голчлон суурилдаг орнуудын хувьд яллах тал шүүгдэгчид холбогдох хэргийг үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх (*beyond reasonable doubt*) нотолгооны стандартад нийцүүлэн тогтоох үүрэгтэй ба шүүх эцсийн шийдвэрийг талуудын мэтгэлцээнд үндэслэн гаргадаг учир харьцангуй уян хатан зохицуулалтын механизм хэрэгжиж байна.

Дийлэнх орнуудад шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр хялбаршуулсан буюу түргэвчилсэн журмаар явуулах процесст шүүхийн хэлэлцүүлэг явуулж байна. ИБУИНХУ-д “*plea guilty*” буюу шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөх практик нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, цаг хугацааг хэмнэх зорилгод нэн тэргүүний ач холбогдол өгч, нэлээд түгээмэл хэрэгждэг. Иймээс эрүүгийн процесс ажиллагааны бүхий л үе шатуудад шүүгдэгчийг гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөхийг дэмжих, боломжийг тайлбарлан ойлгуулах ажиллагаа явагддаг бөгөөд аль болох эрт үе шатанд гэм буруугаа хүлээх тусам хөнгөн ял шийтгэл оногдуулна. Шүүх хуралдааны өмнөх болон шүүх хуралдааны шатанд шүүгдэгч гэм буруугаа хүлээсэн бол заавал нотлох баримт хүлээн авч, талуудын мэтгэлцээнийг сонсох шаардлагагүй. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэргийг шууд эрүүгийн хариуцлага оногдуулах үе шатанд шилжүүлнэ. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн үеэс эхлээд цаашид шүүхийн процесст шүүхийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулах шаардлагагүй гэж үзэж шууд ял оногдуулах асуудалд шилждэг. Харин ОХУ, ХБНГУ, БНХАУ улсуудад шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрч хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэх өргөдөл гаргаж, тохиролцоонд хүрсэн эсэхээс үл хамааран шүүхийн хэлэлцүүлэг буюу шүүх хуралдаан заавал явуулна. ХБНГУ-д шүүгдэгчийн гэм бурууг нотолж буй яллах талын нотлох баримтуудын агуулгыг шүүх хуралдаанд заавал хэлэлцэх бөгөөд шүүхийн шийдвэрт тусгана. Үүний эсрэгээр ОХУ болон БНХАУ-д шүүх хуралдаан зайлшгүй явагдах боловч талуудын мэтгэлцээн, нотлох баримтын агуулгыг дэлгэрэнгүй танилцуулах шаардлагагүй ба шүүхийн шийдвэрт эдгээрийг дурдахад хангалттай байдаг.

Ийнхүү тусгай журмаар буюу шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж гаргасан шүүхийн шийдвэрийн агуулгын шаардлагыг ОХУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгажээ. Бусад улс орнуудад хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн шийдвэрийн агуулгын талаар дэлгэрүүлэн хуульчлаагүй байх ба судалгааны хавсралт хэсэгт ХБНГУ, ОХУ болон БНХАУ-ын жишээ шүүхийн шийдвэрийг оруулсан болно. Эдгээр шийдвэрүүдээс харахад агуулгын хувьд шүүгдэгч хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр гаргасан өргөдөл, түүнд холбогдох гэмт хэргийн зүйл анги, хэргийн үйл баримт, хохирол нөхөн төлсөн эсэх, гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн эсэх, гэмт хэрэг үйлдсэнийг нотлох баримтуудын жагсаалт буюу агуулга, прокурорын санал, түүнийг шүүгдэгч хүлээн зөвшөөрсөн эсэх, шүүхээс өгсөн дүгнэлт болон оногдуулах ял зэргийг нийтлэг тодорхойлж бичсэн байна.

Түүнчлэн хялбаршуулсан буюу шүүгдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрснөөр тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үед шүүхийн нягтлах, хяналт тавих асуудлын хүрээнд шүүгдэгчийг хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгч авах эрхийг баталгаатай хангах асуудал чухалд тавигддаг байна. Заавал өмгөөлөгчтэй зөвшилцсэний үндсэн дээр гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрөх тухай зохицуулалт судалсан орнуудад нийтлэг ажиглагдав. Энэ нь шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр



үүсэх эрх зүйн үр дагаврыг бүрэн ойлгосон эсэх, аливаа дарамт шахалтаас ангид бие даан, өөрийн чөлөөт хүсэлт зоригт үндэслэн гаргах үйл явцыг баталгаажуулж өгөх бөгөөд шүүх үүнд хяналт тавих, шүүх хуралдааны явцад уг асуудлыг тодруулж нягтлах үүргийг АНУ, БНХАУ, ОХУ, ХБНГУ-ын эрүүгийн хууль тогтоомжуудад тодорхой хуульчилжээ. Харин ИБУИНХУ-ын эрүүгийн процессын дүрмүүдэд шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаны дараа ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн процесс болон шүүгдэгчийн эдлэх эрхүүдийг танилцуулах ажиллагаа өрнөдөг байна.



ЭХ СУРВАЛЖ

Гадаад хэл дээр:

- Данила Олешко. *Особый порядок.*(2022)//(Данила Олешко. *Тусгай журам.*(2022))
Цахим холбоос: <https://www.advokatoleshko.ru/blog/tpost/gjzrfu18x1-osobii-poryadok-cto-eto-takoe-zachem-nu;>
- Gary Slapper and David Kelly, *The English legal system* (6th edition), 2003;
- John Spark, *A Practical Approach to Criminal Procedure* (11th edition), 2006

Хууль тогтоомж:

- ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2001 Цахим холбоос: [http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/1727e0ac8e463dde080c9d7a4b41f679115b18e9/;](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/1727e0ac8e463dde080c9d7a4b41f679115b18e9/)
- 中华人民共和国刑事诉讼法, БНХАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Цахим холбоос: <https://www.pkulaw.com/chl/5a06769be1274052bdfb.html?keyword=%E5%88%91%E4%BA%8B%E8%AF%89%E8%AE%BC%E6%B3%95&way=listView;>
- 中华人民共和国刑事诉讼法, БНХАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Цахим холбоос: <https://www.pkulaw.com/chl/5a06769be1274052bdfb.html?keyword=%E5%88%91%E4%BA%8B%E8%AF%89%E8%AE%BC%E6%B3%95&way=listView;>
- Strafprozeßordnung (StPO), Эрүүгийн процесс ажиллагааны хууль, 1987 Цахим холбоос: [https://www.gesetze-im-internet.de/stpo/;](https://www.gesetze-im-internet.de/stpo/)
- Criminal Procedure Rules of UK, ИБУИНХУ-ын Эрүүгийн процессын дүрмүүд, 2020 Цахим холбоос: <https://www.legislation.gov.uk/ukSI/2020/759/contents;>
- Reduction in sentence for guilty plea by Sentencing Council, Гэм буруугаа хүлээснээр оногдуулах ял шийтгэлийг хөнгөрүүлэх удирдамж, 2017 Цахим холбоос: [https://www.sentencingcouncil.org.uk/overarching-guides/crown-court/item/reduction-in-sentence-for-a-guilty-plea-first-hearing-on-or-after-1-june-2017/;](https://www.sentencingcouncil.org.uk/overarching-guides/crown-court/item/reduction-in-sentence-for-a-guilty-plea-first-hearing-on-or-after-1-june-2017/)
- Criminal Practice Direction of UK, ИБУИНХУ-ын Эрүүгийн процессын практик ажиллагааны удирдамж, 2015 Цахим холбоос: https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/924048/crim-practice-directions-VII-sentencing-2015.pdf;
- Federal Rules of Criminal Procedure, АНУ-ын Холбооны Эрүүгийн процессын дүрмүүд, 2020 Цахим холбоос: https://www.uscourts.gov/sites/default/files/federal_rules_of_criminal_procedure_-_december_2020_0.pdf;
- Standards for Criminal Justice: Pleas of Guilty, Эрүүгийн эрх зүйн стандарт: Гэм буруугаа хүлээх ажиллагаа, 1997 Цахим холбоос:



https://www.americanbar.org/groups/criminal_justice/publications/criminal_justice_section_archive/crimjust_standards_guiltypleas_blk/

Цахим эх сурвалж:

- https://beckassets.blob.core.windows.net/product/readingsample/27274142/27274142_9783811445222_leseprobe_02.pdf;
- https://beckassets.blob.core.windows.net/product/readingsample/27274142/27274142_9783811445222_leseprobe_02.pdf;
- https://www.anwalt.de/rechtstipps/was-ist-ein-sogeananter-strafrechtlicher-deal-verstaendigung-im-strafprozess-sinnvoll-oder-nicht_116652.html;
- : <https://www.sentencingcouncil.org.uk/going-to-court/which-court-will-a-case-be-heard-in/#:~:text=%E2%80%9CEither%2Dway%E2%80%9D%20offences%20%E2%80%93,bar%20to%20a%20priceless%20antique>;
- <https://www.sentencingcouncil.org.uk/wp-content/uploads/Consultation-Resource-Assessment-Reduction-in-sentence-for-a-guilty-plea.pdf>;

<https://www.novakazlaw.com/plea-bargaining-in-misdemeanor-cases.html>



ОХУ-ЫН МОСКВА ХОТЫН БАСМАНЫЙ ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ⁶⁰

Оросын Холбооны Улсын нэрийн өмнөөс
Москва хот 2016 оны 04 сарын 12 өдөр
Москва хотын Басманный дүүргийн шүүх дараах бүрэлдэхүүнтэйгээр:
даргалагч шүүгч Вырышева И.В.,
нарийн бичгийн дарга Ю.С.Царева.,
улсын яллагч - туслах Ерохин Д.И.;
шүүгдэгч Сидоров В.Е. болон түүний өмгөөлөгч, Бекшанова Г.Е., оролцоотойгоор,
ОХУ-ын Эрүүгийн хуулийн 158 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «в» заалтад заасан
гэмт хэргийг үйлдсэн хэрэгт буруутгагдаж байгаа ** онд төрсөн, ОХУ-ын иргэн, ерөнхий
суурь боловсролтой, цэргийн алба хаагаагүй, гэрлэсэн, 2 насанд хүрээгүй, 1 нялх хүүхэдтэй,
ажилгүй, ** хаягт бүртгэлтэй, ** хаяг дээр байнга оршин суудаг, өмнө нь ял шийтгэл эдэлж
байгаагүй⁶¹ Сидоров В.Е.-д холбогдох эрүүгийн 1-135/16 дугаартай хэргийн материалыг
шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журмаар нээлттэй шүүх
хуралдаанаар хянан хэлэлцэв.

Тодорхойлов:

Сидоров В.Е. хулгай хийсэн, өөрөөр хэлбэл бусдын эд хөрөнгийг нууцаар хулгайлж,
иргэнд их хэмжээний хохирол учруулсан.

Гэмт хэргийг дараах нөхцөл байдалд үйлдсэн.

2016 оны 2-р сарын 25-ны 00 цаг 10 минутын орчимд Сидоров Москва хот, Земляной
Вал гудамж, 29 байр, 1 барилга гэсэн хаяг дээр байрладаг Москва хотын Курскийн төмөр
замын вокзалын 2-р танхим дахь "KFS" түргэн хоолны рестораны ойролцоо согтуу
байдалтай байхдаа хувийнхаа ашиг сонирхлоор санаатайгаар бусдын эд хөрөнгийг нууцаар
хулгайлах зорилготойгоор *** (хүний нэр) эзэмшдэг «ONE NOUCH 6032X» загварын, 4801
рублийн үнэтэй, хар өнгийн гэртэй (case), дотор нь «Мегафон» үүрэн холбооны операторын
SIM картыг суулгасан, хохирогчийн хувьд материаллаг үнэ цэнгүй "ALCATEL" худалдааны
тэмдэгтэй гар утсыг өөрийн гараар ширээн дээрээс нууцаар хулгайлж, тэрээр өөрийнхөө
үйлдлээрээ гар утасны эзэнд их хэмжээний 4801 рублийн хохирол учруулж, хулгайлсан эд
хөрөнгөө авч хэргийн газраас зугтсан.

Энэ шүүх хуралдаанд шүүгдэгчийн дэмжсэнээр урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр
Сидоровын гаргасан өргөдлийн дагуу эрүүгийн хэргийг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх
ажиллагааны тусгай журмаар хянан хэлэлцэв.

⁶⁰ Приговор Басманного районного суда города Москвы от 12 апреля 2016 года (Уголовное дело № 1-135/16)// (Москвагийн Басманный дүүргийн шүүхийн 2016 оны 4-р сарын 12-ны өдрийн тогтоол (№ 1-135/16 Эрүүгийн хэрэг)) URL: <https://www.mos-gorsud.ru/rs/basmannyj/cases/docs/content/788ba4e9-76f4-40e9-950e-da0fe1956556> (Сүүлд үзсэн: 2023.02.06)

⁶¹ Шийтгэх тогтоолын бор өнгөөр тодруулсан хэсэг нь хувь хүний нууцын мэдээлэлтэй холбоотой мэдээллүүдийг тусгасан байдаг учраас энэхүү шийтгэх тогтоолын эх хувийн хуулбарыг нь шүүхийн цахим хуудаст байршуулахдаа шийтгэх тогтоолын бор өнгөөр тодруулсан хэсэг дэх мэдээллүүдийг тус шүүхийн албан хаагчид нууцалж, арилгадаг. Гэхдээ шийтгэх тогтоолын бор өнгөөр тодруулсан хэсэг дэх мэдээллүүд ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39-р бүлгийн 304 дэх зүйлд зааснаар шийтгэх тогтоолд заавал бичигдэх ёстой мэдээллүүд юм.



Шүүх хуралдааны үеэр шүүгдэгч Сидоров өөрийг нь буруутгаж буй гэмт хэргийг үйлдсэнээ бүрэн хүлээн зөвшөөрсөн.

Сидоров хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахгүйгээр шийдвэр гаргуулах хүсэлтийг сайн дураар гаргасан болохыг, тэр өмгөөлөгчтэйгөө зөвлөлдсөний дараа тэрээр шүүхэд ирүүлсэн өргөдлийн мөн чанар болон үр дагаврыг ойлгосон, түүнд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журмын дагуу гаргасан шийтгэх тогтоолын эрх зүйн үр дагаврыг тайлбарласан болохыг шүүх тогтоов.

Улсын яллагч Ерохин уг хэргийг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журмаар хэлэлцэхийг эсэргүүцээгүй.

Хохирогч *** шүүх хуралдаанд ирээгүй, шүүх хуралдааны товыг зохих ёсоор мэдсэн, түүний шүүхэд бичгээр гаргасан өргөдөлдөө дурдсанаар эрүүгийн хэргийг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журмаар хянан шийдвэрлэхийг эсэргүүцээгүй, эрүүгийн хэргийг өөрийнх нь оролцоогүйгээр хянан шийдвэрлүүлэхийг хүссэн.

Сидоров үндэслэлтэйгээр буруутгагдсан нь хэрэгт цугларсан нотлох баримтаар тогтоогдсон.

Шүүгдэгчийн үйлдлийг шүүх ОХУ-ын Эрүүгийн хуулийн 158 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «в» дэх заалтын дагуу хулгай, өөрөөр хэлбэл бусдын эд хөрөнгийг нууцаар хулгайлж, иргэнд их хэмжээний хохирол учруулсан гэж зүйлчиллээ.

Сидоровыг сэтгэцийн эмчид бүртгүүлсэн баримт байхгүй байгааг харгалзан үзэж, мөн шүүгдэгчийн шүүх хуралдаанд зохих ёсоор биеэ авч явж байгаа болон түүний сэтгэцийн байдалтай холбоотой эргэлзээ шүүхэд төөрөхгүй байна. “Сидоров үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө хариуцлага хүлээх боломжтой мөн хариуцлага хүлээх ёстой, учир нь тэр тус гэмт хэргийг эрүүл ухаантай үйлдсэн тул ОХУ-ын Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэж шүүх дүгнэв.

Шүүх ОХУ-ын Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйл, 60 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу ял оногдуулахдаа үйлдсэн гэмт хэргийн шинж чанар болон нийгмийн аюулын хэр хэмжээ, шүүгдэгчийн хувийн байдлын талаарх мэдээлэл, түүний нас, эрүүл мэндийн байдал, Сидоровыг засахад оногдуулах ялын нөлөө болон түүний гэр бүлийн амьдралын нөхцөл, түүнчлэн шүүгдэгчийн гэмт хэрэгт хандах хандлагыг харгалзан үзнэ.

Шүүгдэгч Сидоров урьд нь ял шийтгэл эдэлж байгаагүй, оршин суугаа газартаа нэр хүндтэй, өвчтэй, гэмт үйлдэл үйлдсэндээ гэмшсэн.

Шүүх түүний ялыг хөнгөрүүлсэн, хүндрүүлсэн нөхцөл байдлыг тогтоогоогүй.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн дагуу гэмт хэргийн ангиллыг хөнгөрүүлэх үндэслэл олдоогүй.

Шүүгдэгч Сидоровын хувийн байдлын талаарх дээрх мэдээлэл болон түүний гэмт хэрэг үйлдсэн бодит нөхцөл байдлыг харгалзан үзэж, үндсэн ялаар торгох, албадан болон засаж залруулах ажил оногдуулах үндэслэлийг ололгүй, хорих ял оногдуулан, шүүх ялтныг засаж залруулах болон түүнийг шинэ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ялын зорилгод ялыг бодитоор эдлүүлэхгүйгээр хүрч болно, өөрөөр хэлбэл, “ОХУ-ын Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйлийг хэрэглэх боломжтой” гэж дүгнэж байна.

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн дагуу шүүх эд мөрийн баримтын асуудлыг шийдвэрлэдэг.

Дээр дурдсан үндэслэлээр, ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 316 дугаар зүйлд заасныг удирдлага болгон, шүүх



ТОГТООВ:

Сидоров В.Е.-г ОХУ-ын Эрүүгийн хуулийн 158 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «в» дэх заалтад заасан гэмт хэргийг үйлдсэнд гэм буруутай гэж үзэн, түүнд 2 /хоёр/ жилийн хорих ял оноосугай.

Сидоров В.Е.-д оногдуулсан 2 (хоёр) жилийн хорих ялыг ОХУ-ын Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйлийн дагуу 2 (хоёр) жилийн болзолт туршилтын хугацаатай гэж үзэж, ялтан дараах үүргийг хүлээлгэх: туршилтын хугацаанд болзолтойгоор ялаар шийтгүүлсэн ялтны зан үйлд хяналт тавих төрийн мэргэшсэн байгууллагад мэдэгдэхгүйгээр байнгын оршин суугаа газраа өөрчлөхгүй байх, тус байгууллагад сард нэг удаа очиж бүртгүүлэх.

Сидоров В. Е.-д авсан улсын хилээр гарахыг хязгаарлах болон өөрийгөө зөв авч явах таслан сэргийлэх арга хэмжээг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл хэвээр үлдээх.

Эд мөрийн баримт: «ONE NOUCH 6032X» загварын, "ALCATEL" худалдааны тэмдэгтэй гар утсыг хохирогчийн эзэмшилд хэвээр үлдээх, дискийг нь - эрүүгийн хэргийн материалтай хамт хадгална.

Шүүхийн шийтгэх тогтоолыг зарласан өдрөөс хойш арав хоногийн дотор ялтан д шийтгэх тогтоолын хуулбарыг хүргүүлсэн өдрөөс хойш мөн хугацаанд шүүхийн шийтгэх тогтоолыг ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 317 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу Москва хотын шүүхэд давж заалдаж болно.

Давж заалдах гомдол гаргасан тохиолдолд ялтан давж заалдах шатны шүүх хураалд оролцох эрхтэй.

Шүүгч

И.В. Вырышева



ЖЭ ЖИААНГ МУЖИЙН ПИНЬ ЯН АЙМГИЙН АРДЫН ШҮҮХИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ТОГТООЛ⁶²

(2023) 0326№31

ЖЭ ЖИААНГ МУЖИЙН ПИНЬ ЯН АЙМГИЙН Ардын прокурорын газраас.

Шүүгдэгч Фан Жэншунь, Эрэгтэй, 1993 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Пинь Ян аймагт төрсөн, Хятад үндэстэн, бага дунд боловсролтой, эрхэлсэн ажил мэргэжилгүй, Пинь Ян мужид оршин суух бүртгэлтэй. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулах гэмт хэрэгт сэжиглэгдэж 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдөр батлан даалтад авч улмаар 7 дугаар сарын 12-ны өдөр, 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр тус тус батлан даалтын хугацааг сунгасан.

Пинь Ян аймгийн Ардын прокурорын газрын прокурор Вэнь Пинь (2022) 853 дугаар яллах дүгнэлтээр гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулах гэмт хэрэг хэрэгт яллаж, 2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр тус шүүхэд ирүүлжээ. Шүүх тухайн өдөр хэрэг үүсгэн, хуульд зааснаар шүүгч дангаар хялбаршуулсан журмаар хэргийг нээлттэй шүүх хуралдаанаар шийдвэрлэлээ. Пинь Ян аймгийн Ардын прокурорын газраас прокурор Мао Хайжүнийг шүүх хуралд оролцуулахаар томилж, шүүгдэгч Фан Жэншунь шүүх танхимд биечлэн шүүх хуралдаанд оролцлоо.

Цагдаагийн байгууллага 2022 оны 06 дугаар сард шүүгдэгчийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж өөрийн нэр дээрх Худалдаа, аж үйлдвэрийн банкны карт (картын дугаар ХХ) болон Бүтээн байгуулалтын банкны картаар (картын дугаар ХХ) Юү Рункэ-д бэлнээр 147600 юань, дансаар 13000 юань тус тус шилжүүлж урамшуулалд нь 2800 юань авсныг түүнчлэн, Бээжин хотын иргэн Ми Моугийн залилангийн хэрэгт холбогдох 33000 юань, Дунг Гуан хотын иргэн Дү Мэйлингийн залилангийн хэрэгт холбогдох 57600 юанийг мөн оны 7, 8-ны өдрүүдэд шүүгдэгч Фан Жэншунь дээрх дурдсан данс руу шилжүүлж, улмаар тухайн өдөр шүүгдэгч дээрх гэмт хэрэгтэнд гаргаж өгсөн нь тогтоогджээ.

Хэргийн дараа, 2022 оны 06 дугаар сарын 14-ны өдөр шүүгдэгч Фан Жэншунь Пинь Ян аймгийн ХХ газар хэргээ хүлээсэн. Хэргийг шүүхээр шийдвэрлэх үед шүүгдэгч хууль бус орлого 2800 юанийг буцаан тушааж, хохирогчийн эдийн засгийн хохиролд 10000 юань нөхөн төлсөн.

Прокурорын газраас шүүгдэгчийн мэдүүлэг, хохирогч Ми мо, Дү мо нарын мэдүүлэг, гэрч Еэ мोगийн мэдүүлэг, таниулах ажиллагааны тэмдэглэл, АТМ-ын хяналтын камерын бичлэг, нотлох баримтын жагсаалт, банкны дансны хуулга, хэрэг бүртгэлийн хуудас, хэрэг нээсэн тогтоол, оршин суугаа газрын бүртгэл зэрэг нотлох баримтаар тогтоосон.

Прокурорын газраас шүүгдэгчийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж бусдад тусалж шилжүүлсэн нь гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж үзэж, гэмт

⁶² БНХАУ-ын шүүхийн шийдвэрийн цахим сан, <https://wenshu.court.gov.cn/> (Сүүлд үзсэн: 2023.01.31)



хэргээ өөрөө илчилсэн, хууль бусаар олсон орлогоо буцаан тушаасан түүнчлэн, хохирогчийн эдийн засгийн хохирлын зарим хэсгийг нөхөн төлсөн, сайн дураараа гэм буруу, хариуцлагыг хүлээн зөвшөөрснийг харгалзан шүүгдэгчид найман сар хугацаатай хорих ялыг, нэг жил хоёр сар тэнсэн харгалзаж, 5000 юаниар торгох саналтай байгааг шүүх хуралдааны үед гаргасан.

Шүүгдэгч дээрх прокурорын газраас тогтоосон хэргийн үйл баримт, оногдуулах ял болон шүүх хуралдаанд гаргасан яллах саналыг эсэргүүцээгүй, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхийг хүлээн зөвшөөрсөн, шүүх хуралдааны үед ямар нэгэн татгалзах санал дурдаагүй болно.

Прокурорын газраас ялласан байдал нь Шүүхээр хэлэлцэж тогтоосон хэргийн бодит байдал, нотлох баримттай нийцэж байна.

Шүүгдэгч Фан Жэншуныг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж бусдад тусалж шилжүүлсэн үйлдэл нь хууль зөрчиж гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулах гэмт хэрэг үйлдсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь үндэслэлтэй буюу прокурорын газрын яллах дүгнэлт үндэслэлтэй байна. Шүүгдэгчийг гэмт хэргээ илчилсэн, хууль бус орлогоо тушаасан, хохирогчийн эдийн засгийн хохирлыг зарим хэсгийг нөхөн төлсөн, сайн дураараа гэм буруу, хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн, гэмт хэрэг үйлдсэндээ гэмшиж байгааг харгалзан хуульд зааснаар ял хөнгөрүүлэн оногдуулах буюу тэнсэн харгалзах зохицуулалтыг хэрэглэлээ. Улсын яллагчаас шүүх хуралдааны үеэр гаргасан эрүүгийн хариуцлагын саналыг тохирсон бөгөөд хэрэглэх үндэслэлтэй байна. Иймд, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 312 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 72 дугаар зүйл, 73 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 64 дүгээр зүйл болон БНХАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 15 дугаар зүйлд зааснаар дараах байдлаар шийдвэрлэлээ:

Нэг. Шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, найман сарын хугацаатай хорих ялыг нэг жил хоёр сар тэнсэн харгалзаж, 5000 юаниар торгох ялаар (төлөгдсөн) шийтгэсүгэй. (Тэнсэн харгалзах туршилтын хугацааг шүүхийн тогтоол батлагдсан өдрөөс эхлэн тоолно.)

Хоёр. Шүүгдэгчийн буцаасан хууль бус орлого 2800 юанийг хурааж, төрийн санд шилжүүлэв.

Хэрэв энэхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авсан хоёр дахь өдрөөс хойш арван хоногийн дотор мөн шүүхээр дамжуулах эсхүл шууд Вэнь Жөү хотын дунд шатны ардын шүүхэд давж заалдаж болно. Бичгээр давж заалдахад эх хувийг, 2 хуулбарын хамт тушаана.

Шүүгч Шиэ Зүе Гая

2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр

Нарийн бичгийн дарга Лин Би

**ЖИ ЛИН МУЖИЙН ЖИААН ХОТЫН АРДЫН ШҮҮХИЙН
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ТОГТООЛ⁶³**

(2022) 0681 дугаар

ЯЛЛАХ БАЙГУУЛЛАГА	Жи лин мужийн Жиан хотын ардын прокурорын газар	
ШҮҮГДЭГЧИЙН ХУВИЙН БАЙДАЛ	Шүүгдэгч Ван моу, эмэгтэй, Хятад үндэстэн, 19xx оны хх сарын хх өдөр Жи лин мужийн хх хотод төрсөн, Иргэний үнэмлэхийн дугаар: 220681xxx, тусгай дунд боловсролтой, ажил мэргэжилгүй. Жи лин мужийн хх хотод оршин суух хаягтай. Хортой хүнс худалдах гэмт хэрэгт сэжиглэгдэж 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр батлан даалтад авсан.	
ЯЛЛАХ БАЙГУУЛЛАГЫН БАЙДАЛ	Яллах дүгнэлтийн дугаар	(2022)хх дугаар
	Ялласан үйл баримт	Шүүгдэгч нь ашиг олох зорилгоор 20xx оноос эхлэн цахимаар дамжуулан худалдаалахыг хориглосон элемент (баруун европын имжийн охь зэрэг 10 төрлийн эрүүл мэндийн бүтээгдэхүүн) худалдсан. Гуан дун мужийн Жун дан компанийн технологийн туршилтаар шалгахад дээрх 10 төрийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнээс Серденафиль найрлага илэрсэн нь <Эрүүл хүнсний бүтээгдэхүүнд нэмэхийг хориглох бодисын жагсаалт>-д заасан шаардлагыг зөрчжээ. Шүүгдэгч нь яллагдаж байгаа хэргийн бодит байдал болон нотлох баримтад тусгай саналгүй, түүнчлэн сайн дураараа гэм буруу, эрүүгийн хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн. Хэргээ өөрөө илчилсэн.

⁶³ БНХАУ-ын Жиан хотын ардын шүүхийн цахим хуудас, <http://bsljfy.e-court.gov.cn/index.shtml> (Сүүлд үзсэн: 2023.01.31)



	Яллаж буй гэмт хэрэг	Хортой хүнс худалдах гэмт хэрэг
	Эрүүгийн хариуцлагын хэмжээний санал	Дөрвөн сар баривчлах ял ⁶⁴ -ыг Зургаан сар тэнсэн харгалзах, торгох ялаар шийтгэх.
ШҮҮГДЭГЧ БОЛОН ӨМГӨӨЛӨГЧИЙН БАЙР СУУРЬ	Шүүгдэгч дээрх хэргийн үйл баримт, оногдуулах ял, яллах саналыг эсэргүүцээгүй, хэргийг түргэвчилсэн журмаар шийдвэрлэхийг хүлээн зөвшөөрсөн, шүүх хуралдааны үед ямар нэгэн татгалзах санал дурдаагүй болно.	
ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ	Улсын яллах байгууллагаас шүүгдэгчийг хортой хүнс худалдах гэмт хэрэгт ялласан нь үндэслэлтэй, ялын хэмжээ тохирсон, хэрэглэх боломжтой байна. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэний дараа хэргээ өөрөө илчилсэн, хэргийн бодит байдлыг мэдүүлсэн болон сайн дураараа гэм буруу, эрүүгийн хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн байх тул хуульд заасны дагуу ялыг хөнгөрүүлэх үндэслэлтэй. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэндээ гэмшиж буй байдал, үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэж тэнсэн харгалзах зохицуулалтыг хэрэглэх үндэслэлтэй байна.	
ХУУЛИЙН ХЭМ ХЭМЖЭЭ	БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 144 дүгээр зүйл, 24 дүгээр зүйл, 52 дугаар зүйл, 53 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 72 дугаар зүйл, 73 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, БНХАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 15 дугаар зүйл.	
ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ	Шүүгдэгч Ван моу-ийг хортой хүнс худалдах гэмт хэрэгт үйлдсэнд тооцож, 4 сар баривчлах ялыг 6 сар тэнсэн харгалзаж, 2000 юаниар торгох ял шийтгэв. (Тэнсэн харгалзах туршилтын хугацааг шүүхийн тогтоол батлагдсан өдрөөс эхлэн тоолно. Торгуулийг энэ тогтоол хүчинтэй болсон өдөр даруй тушаах.)	

⁶⁴ Баривчлах ял нь Хятад улсын эрүүгийн үндсэн ялын төрлийн нэг бөгөөд ялтанд хамгийн ойрхон цагдаагийн байгууллагад нэг сараас дээш, зургаан сараас доош хугацаагаар хоригдоно. Нэг сарын хугацаанд 1-2 хүртэлх удаа гэртээ харих боломжтой түүнчлэн, хөдөлмөрлөсөн бол зохих урамшуулал олгож болохоор хуульчилсан байдаг.



<p style="text-align: center;">ЭРХИЙГ МЭДЭГДЭХ</p>	<p>Хэрэв энэхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авсан хоёр дахь өдрөөс хойш арван хоногийн дотор мөн шүүхээр дамжуулах эсхүл шууд Бая шан хотын дунд шатны ардын шүүхэд давж заалдаж болно. Бичгээр давж заалдахад эх хувийг, 2 хуулбарын хамт тушаана.</p>
<div data-bbox="250 487 467 684" style="border: 1px solid black; padding: 10px; text-align: center;"><p>QR CODE</p></div>	<p style="text-align: right;">Шүүгч Жөү Ли Вэй</p> <p style="text-align: right;">2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр</p> <p style="text-align: right;">Нарийн бичгийн дарга Фан Хая Юань</p>



жолоодох үнэмлэхийг хураах ялын хугацааг сунгах эсвэл өмнөх ял оногдуулсан шүүхийн шийдвэрт тусгаагүй жолоодох эрхийг хасах, тээврийн хэрэгсэл жолоодох үнэмлэх хураах ял оногдуулж болно.

Хэрэв та тогтоосон мөнгөн торгуулийн нэг өдрийн ханшийн хэмжээг бууруулахаар гомдол гаргасан тохиолдолд таны өмгөөлөгч болон прокурорын зөвшөөрлийн үндсэн дээр шүүх хуралдаан явуулахгүйгээр шүүх захирамж гаргаж болно. Захирамжид та шууд гомдол гаргаж болно.

3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал болон бусад зайлшгүй зардлыг өөрөө хариуцах үүргийн талаарх шийдвэрийн эсрэг та гомдол гаргаж болно.

4. Ял оногдуулах шүүхийн шийдвэрт заасан тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах нь энэхүү ял оногдуулах шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноор хэрэгжинэ.

Шүүгч xxxxxxxxxxxxxxxxxxxxxxxx



Хавсралт №5

**ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЭСРЭГ ГАРГАСАН
ГОМДЛООС ТАТГАЛЗАХ⁶⁶**

Орон нутгийн шүүх

Иргэдийн нэрийн өмнөөс

Эрүүгийн хэргийн эсрэг

Шүүгдэгчийн хувийн мэдээлэл

xx

К орон нутгийн шүүхийн 2010 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн шүүх хуралдаанд оролцсон

Шүүгч: xxx

Өмгөөлөгч: xxx

Прокурор: xxx

2010 оны 6 дугаар сарын 17-ны өдөр К орон нутгийн шүүхийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн эсрэг гаргасан гомдлыг татгалзаж шийдвэрлэв.

Яллагдагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хариуцна.

Үндэслэл:

Яллагдагч ял оногдуулсан шүүхийн шийдвэрт хуульд заасан хугацаанд гомдол гаргасан ч шүүх хуралдааны товыг 2010 оны 6 дугаар сарын 29-ний өдөр мэдэгдэх хуудсаар хүргүүлсэн ч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй. Иймд яллагдагчийн гаргасан гомдлыг эрүүгийн процесс ажиллагааны хуулийн 412 дугаар зүйлд зааснаар татгалзаж шийдвэрлэв.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг эрүүгийн процесс ажиллагааны хуулийн 412 дугаар зүйлд үндэслэн шийдвэрлэв.

Шүүгч xxx

⁶⁶ Antrag auf Erlass eines Strafbefehls, ял оногдуулсан шүүхийн шийдвэр гаргуулах хүсэлт. https://www.dreske.de/media/pdf/8b/02/46/9783406613265_LP.pdf



Ял оногдуулсан шүүхийн шийдвэрт гомдол гаргах⁶⁷



⁶⁷ Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа https://www.justiz.nrw.de/Gerichte_Behoerden/ordentliche_gerichte/Strafgericht/BesondereVerfahrensarten/strafbefehlsverfahren/index.php



Америкийн Нэгдсэн Улс

Орегон мужийн Анхан Шатны Дүүргийн Шүүх

АНУ v. Шейн Нелсон Санборн

Гэм буруугаа хүлээх өргөдөл, өмгөөлөгчийн гэрчилгээ, тушаал

Шүүгдэгч шүүхэд илтгэх нь:

1. Миний нэрийг Шейн Нелсон Санборн гэдэг. Би 28 настай. Би 11 дүгээр анги хүртлээ сургуульд сурсан бөгөөд ерөнхий боловсрол эзэмшсэн.
2. Миний өмгөөлөгчийн нэрийг Рубен Л. Инигес гэдэг.
3. Миний өмгөөлөгч бид хоёр миний хэргийн талаар дэлгэрэнгүй ярилцсан. Би шүүхээс шинэчлэн орлуулсан ялын тухай мэдээллийг⁶⁸ хүлээн авч танилцсан бөгөөд өмгөөлөгчтэйгөө энэ талаар ярилцсан. Миний өмгөөлөгч надад энэхүү ялын талаар дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн ба уг хэрэгт холбогдох хөнгөн зүйчлэл, мөн боломжит хууль зүйн хамгаалалтуудын талаар зөвлөсөн. Намайг гэм буруутайд тооцож буй гэмт хэргийн элементүүдийг би сайтар ойлгосон бөгөөд өөрийгөө энэ хэрэгт “ГЭМ БУРУУТАЙ” хэмээн хүлээн зөвшөөрч байна. Миний буруугаа хүлээж буй энэхүү гэмт хэрэг нь 18 U.S.C. § 2423(b) хуулийг зөрчсөн хэрэг буюу хууль бус бэлгийн үйл ажиллагаанд оролцох зорилгоор муж улс дамжин аялсан явдал юм. Энэ хэрэгт холбоотой миний мэдэх бүхий л мэдээлэл, баримтуудыг өмгөөлөгчдөө мэдэгдэх бүрэн боломж надад олдсон. Өмгөөлөгчийн надад өгсөн зөвлөгөөнд сэтгэл хангалуун буй эсэхийг шүүх надаас асууж болно гэдгийг би ойлгож байгаа.
4. Хэрэв би өөрийгөө энэ хэрэгт “ГЭМ БУРУУТАЙ” хэмээн хүлээн зөвшөөрч буруугаа хүлээвэл энэ хэргийн талаар шүүгч надаас асуух аливаа асуултад би заавал хариулах ёстой гэдгийг ойлгож байна. Хэрэв би тангараг өргөн, өмгөөлөгчийн хамт байхдаа худал хариулт хэлбэл миний хэлсэн хариултыг худал мэдүүлэг өгсөн хэргээр миний эсрэг ашиглаж болно гэдгийг мөн ойлгож байна.
5. Би согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөөлд автаагүй байна. Миний бодох сэтгэх чадварт нөлөөлөх аливаа өвчин эмгэг, осол, хөгжлийн бэрхшээл зэрэг байхгүй. Сүүлийн долоо хоногийн хугацаанд би Прозак (100 мг)-аас өөр ямар нэгэн эм, бэлдмэл хэрэглээгүй болно.
6. Гэмт хэрэгт яллагдсанаар шоронд суухаас өөр нэмэлт үр дагаврууд гарч болно гэдгийг ойлгож байна. Тухайлбал, мужаас албадан гаргах, АНУ-аас гаргах, иргэн болох хүсэлтийг татгалзах, улсын ашиг тусыг хүртэхгүй байх, иргэний зарим эрхүүдээс хязгаарлагдах, сонгууль өгөх эрхгүй болох, олон нийтийн албан тушаал хаших эрхгүй болох, галт зэвсэг эзэмших эрхгүй болох, мөн улсаас зөвшөөрөгдсөн зарим ажил мэргэжлийг эзэмших эрхгүй зэрэг орно.

⁶⁸ Superseding Information - шүүгдэгчийг яллах тухай шүүхийн өмнөх шийдвэрийг засах, нэмэх, хасах зэрэг аливаа өөрчлөлт хийж орлуулсан шүүхийн шинэ бичиг.



7. Миний эсрэг буруутгаж буй аливаа гэмт хэрэгт би “ГЭМ БУРУУГҮЙ” хэмээн мэдүүлж болох бөгөөд хэрэв ийнхүү мэдүүлсэн бол тэр мэдүүлэгтээ хэвээр үлдэж, өөрчлөхгүй байж болно гэдгийг ойлгож байна. Хэрэв би “ГЭМ БУРУУГҮЙ” хэмээн мэдүүлбэл Үндсэн хуулиар баталгаажуулсан дараах эрхүүдийг эдэлнэ:
 - a. Хурдан бөгөөд нээлттэй тангарагтны шүүх хурлаар хэргээ хэлэлцүүлж 12 тангарагтны шүүгчдийн олонхын саналаар, үндэслэлтэйгээр гэм буруутайд тооцогдож төрөөс яллагдах хүртэл намайг гэм буруугүй хэмээн үзэх эрх;
 - b. Шүүх ажиллагааны бүх үе шатанд өмгөөлөгчөөр хангуулах эрх;
 - c. Гэрч дуудуулах зэрэг нотлох баримт шинжлэн судлах шүүхийн эрх мэдлийг ашиглах эрх;
 - d. Миний эсрэг мэдүүлэг өгөх бүх гэрчийг харах, сонсох, нүүр тулах, шалгуулах эрх;
 - e. Гэрчээр мэдүүлэг өгүүлэх эсэхийг өөрөө шийдэх эрх;
 - f. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх.
8. Хэрэв би өөрийгөө “ГЭМ БУРУУТАЙ” хэмээн хүлээн зөвшөөрвөл шүүгч болон тангарагтны шүүгч нарын өмнө ямар ч шүүх хурал болохгүй бөгөөд шүүгчийн татгалзсан аливаа шүүх хуралдааны өмнөх саналуудыг давж заалдах эрх надад байхгүй гэдгийг би ойлгож байна.
9. Дүрэм 11(с)(1)(В)-д заасны дагуу энэ хэрэгт би өөрийгөө “ГЭМ БУРУУТАЙ” хэмээн хүлээн зөвшөөрч гэм буруугаа хүлээж байна. Миний өмгөөлөгч надад Дүрэм 11(с)(1)(В)-д заасны дагуу гэм буруугаа хүлээхийн үр дагавруудыг тайлбарлаж өгсөн. Үүнд:

Миний гэм буруугаа хүлээж буй хэлцлийн талаар Дүрэм 11(с)(1)(В)-д заасан. Иймд, хэдийгээр шүүгч нь прокурор болон өмгөөлөгч нарын тавьсан ялын тухай санал болон тохиролцоонуудыг харгалзан авч үзэх боловч тэдгээр санал болон тохиролцоонуудыг дагаж мөрдөх албагүй. Хэрэв шүүгч нь миний прокурортой хийсэн гэм буруугаа хүлээх хэлцлийн гэрээний нөхцөлийн дагуу тохиролцсон ялаас өөр ял оногдуулбал энэхүү гэм буруугаа хүлээх хэлцлийг орхин татгалзах эрх надад байхгүй.
10. Гэм буруугаа хүлээж буй энэхүү гэмт хэргийн ялын дээд хэмжээ нь 30 жил хорих ял, мөн \$250,000-ийн торгууль төлөх гэдгийг би ойлгож байна.
11. Бусад торгуулиудаас гадна нэмж \$100-ийг хуулиар заасны дагуу тусгай үзлэг хэмээн шүүгч нэхэмжлэх болно гэдгийг би ойлгож байна.
12. Хэрэв надад оногдсон мөнгөн торгуулийг би сайн дураараа төлөхөөс татгалзвал шүүхэд ахин дуудагдаж төлөөгүй үлдсэн төлбөрийн хэмжээ өмнөхөөсөө ихсэх бөгөөд би нэг жил хүртэлх хугацаагаар шоронд хоригдож болохыг ойлгож байна.
13. Миний өмгөөлөгч надтай Холбооны ял шийтгэлийн удирдамжийн тухай ярилцсан. Энэхүү удирдамж нь зөвхөн зөвлөмжийн төдий бөгөөд заавал дагаж мөрдөх албагүй гэдгийг би ойлгож байна. Ялыг тогтоож буй шүүгч нь шийдвэр гаргахдаа 18 U.S.C. § 3553(a)-д заасны дагуу дараах хүчин зүйлсийг авч үзэх ёстой. Үүнд: гэмт хэргийн мөн чанар болон нөхцөл байдал; миний хувийн түүх болон зан төлөв; ялын зорилго (шийтгэх, сэргийлэх, хамгаалах, засан хүмүүжүүлэх); мөн удирдамжийн дагуу ялын дээд, доод хэмжээ гэх мэт. Миний өмгөөлөгч эсхүл өөр хэн нэгэн хүн миний ялыг



удирдамжийн дагуу тооцож өгөх нь зөвхөн урьдчилан таамаглах, зөвлөх төдий бөгөөд энэ нь шүүгч ялыг тогтоож эцсийн шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлсийн ердөө нэг нь гэдгийг би ойлгож байна. Мөн шүүгч 10 дугаар догол мөрд заасан ялын дээд хэмжээнээс өндөр ял оногдуулахгүй гэдгийг ойлгож байна.

14. Миний өмгөөлөгчийн надад зөвлөснөөр ял шийтгэлийн удирдамжийн дагуу хэрэв би хорих ял шийтгүүлбэл үүнийг тэнсэх боломжгүй гэдгийг ойлгож байна. Надад оногдсон ялыг би бүрэн гүйцэт дуустал нь эдлэх ёстой бөгөөд хэрэв би дэглэмийг сайн сахиж сахилга батын кредит оноо цуглуулж чадвал тэр нь ялын хугацаанаас хасагдаж болно. Шоронд өнгөрүүлэх нэг жил бүрээс 54 өдөр хүртэлх хугацаагаар хасагдах кредит цуглуулж болно. Уг кредит нь нэг жил болон түүнээс бага хугацааны ялд үйлчлэхгүй.
15. Хэрэв би хорих ял шийтгүүлбэл шүүгч надад хорих ялын хугацаа дууссаны дараах хяналттайгаар суллах хугацааг заана. Энэхүү хяналттайгаар суллах хугацаанд шүүгчийн тогтоосон нөхцөлийн дагуу хяналтын ажилтан намайг хянах болно. Миний хэргийн хувьд сулласны дараах хяналтын хугацаа нь 5-аас доошгүй жил байна. Хэрэв би хяналттайгаар суллах нөхцөлийг зөрчвөл шоронд ахин 5 хүртэлх жилээр сууж болно.
16. Бусад шийтгэл дээр нэмж эсхүл оронд нь шүүгч хохирогч талд нөхөн төлбөр олгох нэхэмжлэл гаргаж болно гэдгийг би ойлгож байна. Зарим хүчирхийлэл болон луйвар орсон гэмт хэргүүд дээр шүүгч хохирогч талд учирсан санхүүгийн хохирол болон бусад гэм хорыг арилгах бүрэн нөхөн төлбөр зайлшгүй олгох ёстой. Энэ тохиолдолд хохирогч нөхөн төлбөр олгох нэхэмжлэлийг иргэний шүүхийн эд хөрөнгө нэхэмжлэх эрх болгон ашиглаж болно. Нөхөн төлбөрийн нэхэмжлэл нь намайг шоронгоос суллагдсан хугацаанаас хойш 20 жил хүртэлх хугацаанд улсаас албадан төлүүлэх хүчинтэй байдаг. Хэрэв би хорих ялаар шийтгүүлэхгүй бол шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш мөн 20 жилийн хугацаатай байдаг. Хэрэв би өөрөө сайн дураар тус төлбөрийн нэхэмжлэлийг төлөхөөс татгалзвал шүүх намайг дахин яллаж болох юм.
17. \$2,500 болон түүнээс дээш хэмжээний нөхөн олговор буюу торгууль төлөх нөхцөлд хэрэв 15 өдрийн дотор төлж барагдуулаагүй бол бусад нөхцөлд хүү бодож төлөх ёстой гэдгийг би ойлгож байна.
18. Хэрэв би өөр бусад муж улсад тэнсэн харгалзах болон хяналттайгаар суллагдах тохиолдолд уг шүүхэд буруугаа хүлээж буй хэлцлээс үүдэх тэнсэн харгалзах болон хяналттайгаар суллагдах нөхцөлүүд цуцлагдаж болох бөгөөд энэхүү шүүхээс оногдох ялаас гадна нэмэлт ял шийтгэл эдэлж болно гэдгийг би ойлгож байна.
19. Хэрэв надад өөр муж улсын шүүхээс ял шийтгэл оногдуулах бол миний энэ шүүхэд гэм буруугаа хүлээж буй хэлцэл нь бусад муж улсын шүүхийн хэрэгт нөлөөлөхгүй бөгөөд би давхар ял шийтгэл эдлэх ёстой гэдгийг ойлгож байна.
20. Миний “ГЭМ БУРУУТАЙ” хэмээх хэлцэл нь Гэм буруугаа хүлээх гэрээ, тохиролцоонд үндэслэсэн бөгөөд уг гэрээг би прокурортой тохиролцон хийсэн болно. Би уг гэрээг уншиж ойлгосон бөгөөд надад тайлбарлаж өгсөн.
21. Гэм буруугаа хүлээх гэрээ нь зөвхөн АНУ-ын төр болон миний хооронд хийгдэх тохиролцоо юм. Өөр бусад ямар ч цагдаа эсхүл төрийн аливаа салбарын ажилтан эсхүл хэн нэгэн надад хэрэв би “ГЭМ БУРУУТАЙ” хэмээн хүлээн зөвшөөрвөл илүү хөнгөн ял шийтгэл хүлээх болно хэмээн гэм буруугаа хүлээх гэрээнд заасан нөхцөлийг амлах эсхүл санал болгоогүй болно.



22. Миний “ГЭМ БУРУУТАЙ” хэмээх хэлцэл нь аливаа хүч, заналхийлэлд болон айлган сүрдүүлэлт дээрээс үүсээгүй юм.
23. Иймд би шүүгчийг миний “ГЭМ БУРУУТАЙ” хэмээх хэлцлийг хүлээн авч шинэчлэн орлуулсан ялын тухай мэдэгдэлд оруулж өгнө үү хэмээн хүсэж байна.
24. Миний “ГЭМ БУРУУТАЙ” хэмээх хэлцлийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө шүүгч эхлээд гэмт хэрэг гарсан, тус гэмт хэргийг би үйлдсэн болохыг тогтоох ёстой гэдгийг ойлгож байна. Гэм буруугаа хүлээж буй энэхүү хэрэгт би дараах үйлдлүүдийг хийсэн бөгөөд эдгээр нь үнэн болохыг хүлээн зөвшөөрч байна:

2014 оны 8 дугаар сарын 26-ний өдөр Орегон мужийн дүүрэг болон ойр хавьцаагаас (Орегон мужаас Вашингтон муж руу) би А.Ж. гэх этгээдтэй хууль бус бэлгийн харилцаанд орох зорилготойгоор муж улс дамжин аялал хийсэн.

25. Би “ГЭМ БУРУУТАЙ” гэх хэлцлээ өөрийн чөлөөт сонголтоор, сайн дураар, бүрэн ойлгож хийсэн бөгөөд шинээр орлуулсан яллах тухай мэдээлэл болон энэхүү өргөдөлд хавсарсан намайг буруутгаж буй гэмт хэргийг бүрэн хүлээн зөвшөөрч бүрэн ойлгож байна.

2017 оны 3 дугаар сарын 28-ний өдөр энэхүү өргөдлийн бүх хуудас, мөрийг би уншсан ба надад уншиж өгсөн бөгөөд өөрийн хуульчийн дэргэд батлан гарын үсгээ зурсан болно.

Өмгөөлөгчийн гэрчилгээ

Шейн Нелсон Санборн-ийн өмгөөлөгч би мөн гарын үсгээ зурж дараах зүйлсийг баталж байна:

1. Шинэчлэн орлуулсан яллах тухай мэдэгдэлд бичсэн шүүгдэгчийг гэм буруутайд үзэж буй хэргийг би шүүгдэгчид бүрэн тайлбарлаж өгсөн бөгөөд аливаа хөнгөн хэргүүд болон боломжит хууль зүйн хамгаалалтуудыг тайлбарлаж өгсөн.
2. Гэм буруутайгаа хүлээх хэлцэл хүссэн өргөдөл болон хэлцэл хийх тушаалыг биечлэн үзэж нягталсан бөгөөд эдгээрт орсон бүхий л заалтуудыг шүүгдэгчид бүрэн тайлбарлаж өгсөн ба өргөдөлд тусгасан бүхий л асуудлуудыг шүүгдэгчтэй ярилцаж хэлэлцсэн болно.
3. Уг өргөдлийн 6-аас 20 дугаар мөрөнд тусгасан гэм буруутайгаа хүлээх хэлцэл хийснээр гарах бүхий л үр дагаврууд болон ялын дээд хэмжээг, түүнчлэн Холбооны ял шийтгэлийн удирдамжийг би шүүгдэгчид бүрэн тайлбарлаж өгсөн болно.
4. Шүүгдэгчийн “ГЭМ БУРУУТАЙ”-гаа хүлээх хэлцлийг шүүх хүлээн авч зөвшөөрөхийг санал болгож байна.

2017 оны 3 дугаар сарын 28-ний өдөр Гэм буруутайгаа хүлээх хэлцэл хүссэн өргөдөл болон Гэм буруутайгаа хүлээх хэлцлийн гэрээнд орсон заалтуудыг дээр дурдсан шүүгдэгчтэй бүрэн дэлгэрэнгүй ярилцсан бөгөөд шүүгдэгчийн дэргэд батлан гарын үсгээ зурав.



Орегон муж улсын Мултнома хотын Анхан шатны дүүргийн шүүхийн шийдвэр

Орегон муж vs. Питер Жорж Жиросек

Шүүх хурлын нээлт

Шүүгдэгч нь төлбөрийн чадамжгүй бөгөөд шүүхээс өмгөөлөгчөөр хангаж өгөв. Шүүгдэгчийг төлөөлөх өмгөөлөгч нь Валери Вин Рон. Хохирогчийг төлөөлөх өмгөөлөгч нь Тара Гарднер.

Холбогдох гэмт хэргүүд

Шүүгдэгчийг дараах гэмт хэргүүдэд гэм буруутайд тооцов:

Гэмт хэрэг 1: Нэгдүгээр түвшний Хулгайн гэмт хэрэг

Гэмт хэрэг 1, Нэгдүгээр түвшний Хулгайн гэмт хэрэг, 164.225, Гэмт хэргийн ангилал А, 2016 оны 7 дугаар сарын 17-ноос 2016 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн хооронд үйлдсэн. Гэмт буруутайд тооцох үндэслэл нь 2016 оны 12 дугаар сарын 28-ний өдөр Гэм буруугаа хүлээсэн хэлцэл болно.

Ялын удирдамж

Гэмт хэрэг 1-ийн Гэмт хэргийн хүндийн зэрэглэл (ГХХЗ) нь 7 бөгөөд Гэмт хэргийн түүхийн зэрэглэл (ГХТЗ) нь Н юм.

Энэхүү ял нь дараах онцгой нөхцөлийн дагуу үндэслэгдэнэ:

- Энэ бол урьдчилсан таамаглал бүхий ял

Тэнсэн харгалзах

Шүүгдэгчд 36 сарын турш хяналттайгаар тэнсэн харгалзах ялыг оногдуулах бөгөөд дараах нөхцөлүүдийг шаардана:

- Шүүхээс томилогдсон хяналтын төлбөр, торгууль, нөхөн олговор, болон бусад төлбөрүүдийг төлнө.
- Эмчийн жороор олгохоос бусад бүх төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх эсхүл эзэмшихийг хориглоно.
- Хэрэв шүүгдэгч өмнө нь сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж байсан түүхтэй бол эсхүл шүүгдэгчийг хууль бусаар энэ төрлийн бодис хэрэглэсэн гэж үзэх үндэслэл бий бол шүүгдэгч шинжилгээ өгөх.
- Хэрэв шүүгдэгчийг сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж байсан түүхтэй гэж үзэх үндэслэл бий бол энэ төрлийн бодис хэрэглэхийг зогсоох арга хэмжээнд оролцож хяналт тавьж буй мэргэжилтний зөвлөгөөг дагна.



- Хорих ангийн хэлтсээс эсхүл мужийн засан хүмүүжүүлэх нийгэмлэгийн холбооноос зөвшөөрсөн бичиг олгохоос нааш Орегон муж улсын хэлээр гарахгүй байх.
- Хэрэв боломжтой бол бүтэн цагийн ажилд орох эсхүл итгэмжлэгдсэн сургуульд сурах эсхүл аль алийг нь хийх. Энэ шаардлагаас чөлөөлөгдөх үндэслэлийг шүүхээс тогтооно.
- Хорих ангийн хэлтсээс эсхүл мужийн засан хүмүүжүүлэх нийгэмлэгийн холбооноос зөвшөөрөлгүйгээр ажил эрхлэлт болон оршин суух хаяг солихыг хориглоно.
- Хяналтын ажилтныг шүүгдэгч өөрийн ажлын байр болон оршин суугаа байрыг биеэр зочлон ирж үзэж шалгахыг зөвшөөрөх.
- Хэрэв хяналтын ажилтан зөрчил гаргасан эд мөрийн баримт байна гэж үзвэл хурууны хээ болон гэрэл зургийг Хорих ангийн хэлтэс эсхүл мужийн засан хүмүүжүүлэх нийгэмлэгийн холбооны хүсэлтээр шүүгдэгчийн биеийг, автомашиныг, мөн оршин суугаа байрыг нэгжихийг зөвшөөрөх.
- Холбооны, мужийн, хотын, дүүргийн бүхий л хууль, дүрмүүдийг сахиулах.
- Хорих ангийн хэлтсээс эсхүл мужийн засан хүмүүжүүлэх нийгэмлэгийн холбооноос тавих бүхий л үндэслэлтэй асуултуудад үнэнээр хариулах.
- Аливаа зэвсэг, буу галт зэвсэг, болон аюултай амьтан эзэмшихгүй байх.
- Хэрэв хяналтын ажилтан шаардлагатай гэж үзвэл бэлгийн хүчирхийллийн эсрэг программ-д хамрагдах ёстой бөгөөд полиграф үзлэгээр шалгуулах ёстой.
- Шаардлагатай тохиолдолд сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгт мөн хамрагдах ёстой.
- Хяналтын ажилтны зааврыг чанд дагаж мөрдөх.
- Шаардлагатай гэж үзвэл бэлгийн хүчирхийлэгч эсэх талаарх хуулийн дагуу Улсын цагдаагийн газар мэдэгдэж бүртэл үүсгэн хараа хяналт доор байх ёстой.
- Хяналтын ажилтны зааврын дагуу эрсдэлийн оношилгоо хийлгэх.

Түүнчлэн, шүүгдэгч тэнсэн харгалзах онцгой нөхцөлийн дагуу дараах шаардлагуудыг биелүүлэх ёстой:

- Хэрэв шаардлагатай бол архи болон сэтгэцэд нөлөөлөх бодисоос гаргах эмчилгээнд хамрагдаж холбогдох курс эмчилгээний ангийг дүүргэж хяналтын ажилтнаар үр дүнг шалгуулах ёстой.
- Оюун ухааны хөгжлийн программ-д хамрагдах.
- Даниел Дехан-аас уучлал хүссэн захидал бичих.



- 2.5 нэгж нийгмийн үйлчилгээний ажил хийх.
- Хохирогч Даниел Дехан-тай хувийн харилцаа тогтоохгүй байх.
- Хэрэг гарсан газрын ойролцоо хууль бусаар нэвтрэхгүй байх.

Хуулийн заалтууд

Шүүгдэгч нь цус болон шүлсний дээж өгч мөн хурууны хээг таниулах ёстой.

Мөнгөн дүн

Шүүгдэгч дараах мөнгөн торгуулийг төлөх ёстой:

Нөхөн олговор:

Нөхөн олговрыг доор дурдсан хүлээн авагч нарт шүүхээс хүлээн аван тарааж өгнө.

Гэмт хэрэг 2: Нэгдүгээр түвшний Хулгайн гэмт хэрэг

Гэмт хэрэг 2, Нэгдүгээр түвшний Хулгайн гэмт хэрэг, 164.055, Гэмт хэргийн ангилал С, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр үйлдсэн. Гэмт буруутайд тооцох үндэслэл нь 2016 оны 12 дугаар сарын 28-ний өдөр Гэм буруугаа хүлээсэн хэлцэл болно.

Ялын удирдамж

Гэмт хэрэг 2-ийн Гэмт хэргийн хүндийн зэрэглэл (ГХХЗ) нь 3 бөгөөд Гэмт хэргийн түүхийн зэрэглэл (ГХТЗ) нь Н юм.

Шүүх энэхүү хэрэгт энгийн үед буюу ихэнх тохиолдолд оногдуулдаг ялын хэмжээнээс харьцангуй өндөр ялыг сонгох зайлшгүй шалтгаан байна гэж үзэв:

- Талуудын хоорондох гэрээн дээр үндэслэв.

Тэнсэн харгалзах

Шүүгдэгчд 36 сарын турш хяналттайгаар тэнсэн харгалзах ялыг оногдуулах бөгөөд дараах нөхцөлүүдийг шаардана:

Шүүгдэгч тэнсэн харгалзах тухай бүхий л ерөнхий шаардлагуудыг хангана.

Түүнчлэн, шүүгдэгчид мөн дараах онцгой нөхцөлийг тавина:

- Тэнсэн харгалзах тухай нөхцөлүүд нь гэмт хэрэг 1 болон 2 дээр адилхан байна.
- Гэмт хэрэг 2 дээрх бүх төлбөр, мөнгөн торгуулиуд хүчингүй болсон.

Хуулийн заалтууд



Шүүгдэгч нь цус болон шүлсний дээж өгч мөн хурууны хээг таниулах ёстой.

Гэм буруутайд тооцоогүй гэмт хэргүүд

Гэмт хэрэг 3, Нэгдүгээр түвшний Хулгайн гэмт хэрэг хүчингүйд тооцов.

Гэмт хэрэг 4, Нэгдүгээр түвшний Хулгайн гэмт хэрэг хүчингүйд тооцов.

Хэрэв хүнд гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл зэргийг үйлдэж байсан бол шүүгдэгч буу галт зэвсэг, бууны сум, болон бусад зэвсгүүдийг хувийн болон мэргэжлийн үүднээс худалдан авах, зарах, зөөвөрлөх, хүлээн авах, болон эзэмших эрхээ алдана.

Нөхөн олговор олгох мөнгөн дүнгүүд

Дараах хүлээн авагч нарт шүүгдэгч нөхөн олговор болох мөнгөн торгуулийг төлнө.

Төлбөрийн хуваарь

Дээрх нөхөн олговрыг хийх он цагийн хуваарийг шүүхийн ажилтнаас тодорхой болгоно.